МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Хассуурийн ГАНХУЯГ
14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон,
Утас: 26-15-55, Факс: 32-70-16
E-mail: gankhuyagkh@parliament.mn
http://www.parliament.mn

2021-06-21 № ЧШХ-03/5466.

танай _____-ны № _____-т

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ЕРӨНХИЙ НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА Л.ӨЛЗИЙСАЙХАН ТАНАА

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх
тов тогтоолгох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Хууль тогтоомжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ дагуу "Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлэх бусад хууль, тогтоолын төсөл"-ийг боловсруулаа.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 40 дүгээр зүйлд заасны дагуу хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх тов тогтоож өгнө үү.

Хуулийн төсөл, үзэл баримтлал, танилцуулга болон холбогдох материалыг хавсаргав.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ГИШҮҮН П.АНУЖИН

Х.ГАНХУЯГ

Б.ЖАРГАЛМАА

УХА0317

2021000557

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Хассуурийн ГАНХУЯГ
14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон,
Утас: 26-15-55, Факс: 32-70-16
E-mail: gankhuyagkh@parliament.mn
http://www.parliament.mn

2021.06.21 № ҮИХ-03/5768

танай _____-ны № _____-т

МОНГОЛ УЛСЫН ИХ
ХУРЛЫН ДАРГА ГОМБОЖАВЫН
ЗАНДАНШАТАР ТАНАА

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Хууль тогтоомжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ дагуу "Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлэх бусад хууль, тогтоолын төсөл"-ийг санаачлан боловсруулж, Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын Байнгын болон нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж өгнө үү.

Хүндэтгэсэн,

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ГИШҮҮН П.АНУЖИН

Х.ГАНХУЯГ

Б.ЖАРГАЛМАА

УУА0317

2021000554

МОНГОЛ УЛС
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

20 21 он 06 дугаар сарын 10-ны өдөр

Дугаар ХЭГ/1515

Улаанбаатар-12
Утас: 260817
Факс: 976-11-310011

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Х.ГАНХУЯГ ТАНАА

Хуралдааны тэмдэглэл
хүргүүлэх тухай

Таны санаачлан боловсруулсан Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль болон хамт өргөн мэдүүлэх бусад хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцсэн Засгийн газрын 2021 оны 6 дугаар сарын 8-ны өдрийн хуралдааны тэмдэглэлийг хүргүүлж байна.

Хүлээн авч, танилцана уу.

Монгол Улсын сайд,
Засгийн газрын Хэрэг
эрхлэх газрын дарга Ц.НЯМДОРЖ

000021508225

МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 6 дугаар сарын 8-ны өдрийн хуралдааны 34 дүгээр тэмдэглэлд:

"II.ХЭЛЭЛЦСЭН нь: Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуягийн санаачлан боловсруулсан Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль болон хамт өргөн мэдүүлэх бусад хууль, Улсын Их Хурлын тогтоолын төсөлд Засгийн газраас өгөх санал, дүгнэлт

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуягийн санаачлан боловсруулсан Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль болон хамт өргөн мэдүүлэх бусад хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцээд дараахь санал, дүгнэлтийг хууль санаачлагчид уламжлахаар тогтов. Үүнд:

1. Засгийн газрын 2017 оны 289 дүгээр тогтоолоор баталсан "Халдварт бус өвчинтэй тэмцэх үндэсний хөтөлбөр"-ийн 3.1.8-д "архи, тамхи, чихэрлэг хүнс зэрэг хүний эрүүл мэндэд эрсдэл учруулдаг хэрэглээг үнэ, татварын бодлогоор дамжуулан бууруулах, архи, тамхинд ногдуулах албан татварын хэмжээг жижиглэнгийн үнийн 50 хувьд хүргэх, усан болон электрон тамхины зохицуулалтыг утаат тамхины зохицуулалттай адилтгах асуудлыг холбогдох хууль тогтоомжид тусгах замаар шийдвэрлэх" гэж заасан.

Гэтэл хуулийн төсөлд тусгасан халаах болон ууршуулах технологи бүхий электрон төхөөрөмжийн тусламжтайгаар хэрэглэгддэг тамхи, никотин агуулсан шингэн тамхи нь дээрх хөтөлбөрт тусгасан усан болон электрон тамхины ангилалд хамаарч байгаа эсэх нь тодорхойгүй байх тул нэр томьёоны тайлбарт анхаарч, Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахтай холбогдуулан "усан" болон "электрон" тамхины нэр томьёоны тодорхойлолтыг тодорхой зааж оруулах нь зүйтэй.

Мөн гаалийн бараа тодорхойлох, кодлох уялдуулсан системийн олон улсын стандартад нийцүүлэн халаадаг тамхи, электрон тамхи, электрон тамхи цэнэглэх шингэний тодорхойлолтыг дараахь байдлаар томьёолох саналтай байна:

-"Халаадаг тамхи" гэж халаах хэрэгсэл ашиглан тамхин бүтээгдэхүүнийг халаах явцад үүсэж буй никотин бүхий уурыг амаараа сорж татах зориулалттай үйлдвэрийн аргаар бэлтгэсэн тамхи;

-"Электрон тамхи" гэж никотин, эсхүл орлуулагч агуулсан шингэн уусмалтай, түүнийг халаах, ууршуулах замаар хүний биед дамжуулах хэрэгсэл (нэг удаагийн болон олон удаагийн хэрэглээний);

-"Электрон тамхи цэнэглэх шингэн" гэж электрон тамхи болон түүнтэй адилтгах бусад тамхинд ашиглах зориулалттай никотин, эсхүл орлуулагч агуулсан шингэн, уусмал (нэг удаагийн хэрэглээний савлагаатай, эсхүл дүүргэж, сэлбэж хэрэглэхээр савлагдсан байж болно).

Түүнчлэн, хуулийн төсөлд зөвхөн халаадаг болон электрон тамхинд онцгой албан татвар ногдуулахаар заасан нь учир дутагдалтай байх тул "электрон тамхи болон электрон тамхи цэнэглэх шингэн" гэж хамтад нь томьёолж татвар ногдуулах нь зүйтэй.

Энэ хүрээнд никотин, эсхүл орлуулагч агуулсан зажлах, амандаа уусгах, биед наах, усан хоолойгоор татах зэрэг зориулалттай үйлдвэрийн аргаар бэлтгэсэн бусад төрлийн тамхи, тамхин бүтээгдэхүүнийг нэгтгэх саналтай байна.

2. 2014 оны 10 дугаар сарын 13-18-ны өдрүүдэд ОХУ-ын Москва хотод болсон Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагын Тамхины хяналтын суурь конвенцид оролцогч талуудын Зургаадугаар бага хуралдааны үеэр "Электрон никотин дамжуулах систем" (ENDS)-ийн талаарх тайлан, судалгааг танилцуулсан бөгөөд уг судалгаанд халаадаг болон электрон тамхи нь хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй, хүүхэд, залуучуудыг тамхинд татан оруулах, донтуулах эрсдэл үүсгэж байгаа талаар дурдсан байна.

Дээрх нөхцөл байдлаас шалтгаалан дэлхийн 13 улс тухайн төрлийн тамхинд хязгаарлалт тогтоогоод байгаа бөгөөд 15 улсад үйлдвэрлэх, импортлох, сурталчлах үйл ажиллагааг бүрэн хориглосон байна. Иймд халаах болон ууршуулах технологи бүхий электрон төхөөрөмжийн тусламжтайгаар хэрэглэгддэг тамхи, никотин агуулсан шингэн тамхинд агуулагдах бодисын хүний биед үзүүлэх гаж нөлөө, эрүүл мэндэд учруулах хор уршиг, нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөллийн талаарх судалгааг Хууль тогтоомжийн тухай хуульд нийцүүлэн хийх нь зохимжтой гэж үзэж байна.

Түүнчлэн, Тамхины хяналтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.7.14-т заасан "дотуур байраас 500" гэснийг хасахаар заасан нь хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан хүүхэд, залуучуудын тамхины хэрэглээг бууруулах, тамхигүй орчин бүрдүүлэх практик шаардлагатай зөрчилдөж байгааг анхаарах шаардлагатай.

3. Эрүүл мэндийг дэмжих санд төвлөрүүлэх тамхины онцгой татварын 2 хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг 1 хувь болгон бууруулахаар тусгасан нь тус сангийн зориулалтын дагуу эрүүл мэндийн мэдээлэл, сургалт, сурталчилгаа, ухуулга нөлөөлөл, тандалт судалгааны ажлыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх, тэр дундаа сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах, архи, тамхи, мансууруулах бодисын хорт нөлөөллөөс сэргийлэх ажлыг хэвийн, үр дүнтэй хэрэгжүүлэхэд хүндрэл учруулж болзошгүй байна.

4. Татварын ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсэг, Улсын Их Хурлын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.3 дахь хэсэгт заасны дагуу татвар ногдуулах, төлөх, тайлагнах, татварын хувь, хэмжээ болон суурийг өөрчлөх асуудлыг Засгийн газар боловсруулан жил бүрийн төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байх нь зүйтэйг анхаарах.” гэжээ.

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

БАТЛАВ.
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН **Х.ГАНХУЯГ**

ОНЦГОЙ АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг. Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага:

Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах дараах хууль зүйн үндэслэл, практик шаардлага байна.

1.1. Хууль зүйн үндэслэл

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын "Тамхины хяналтын суурь конвенци"-д манай улс 2004 онд нэгдэн орсон. Энэ конвенцын 3 дугаар хэсгийн 6 дугаар зүйлд тамхины татварыг нэмэгдүүлэх нь тамхины хэрэглээг дорвитой бууруулах хамгийн сайн хөшүүрэг болохыг уг конвенцид нэгдсэн улсууд хүлээн зөвшөөрч байгааг дурдсан байдаг.

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолоор баталсан "Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл"-ийн 136-д зарим шинэ төрлийн тамхи, тамхин бүтээгдэхүүний хэрэглээг зохицуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх чиглэлээр Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулахаар тусгагдсан.

Мөн Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 289 дүгээр тогтоолоор баталсан "Халдварт бус өвчинтэй тэмцэх үндэсний хөтөлбөр"-т заасан Хүн амын эрүүл аж төрөх мэдлэг, хандлагыг сайжруулах, байгууллага, аж ахуйн нэгжид эрүүл мэндийг дэмжих орчин бүрдүүлэх замаар халдварт бус өвчинд нөлөөлж байгаа анхдагч болон завсрын эрсдэлт хүчин зүйлсийн тархалтыг бууруулах зорилт /Зорилт 1/-ын хүрээнд "...тамхи ... зэрэг хүний эрүүл мэндэд эрсдэл учруулдаг хэрэглээг үнэ, татварын бодлогоор дамжуулан бууруулах, архи, тамхинд ногдуулах албан татварын хэмжээг жижиглэнгийн үнийн 50 хувьд хүргэх, усан болон электрон тамхины зохицуулалтыг утаат тамхины зохицуулалттай адилтгах асуудлыг холбогдох хууль тогтоомжид тусгах замаар шийдвэрлэх"-ээр заасан байна.

1.2. Практик шаардлага

Өнөөдөр дэлхий дахинаа хэрэглэж байгаа хүмүүсийнхээ 50%–ийг үхэлд хүргэдэг бөгөөд урьдчилан сэргийлж болох үхлийн шалтгаан бол тамхи юм. Тамхины хэрэглээ нь дэлхий даяар нас баралтын тэргүүлэх шалтгаануудын гол эрсдэлт хүчин зүйл болдог бөгөөд ойролцоогоор 5 нас баралт тутмын 1 нь тамхины хэрэглээтэй холбоотой байна (Олон улсын эрүүл мэндийн үнэлгээний институт, Вашингтоны их сургууль). Дэлхий дахинд эрт нас баралтын (70 наснаас өмнөх нас баралт) тэргүүлэх шалтгаануудын нэгд тамхидалт орж байна. 2017 онд

дэлхий дахинд нийтдээ 8 сая хүн тамхидалттай холбоотой өвчний улмаас нас баржээ.

Олон улсын эрүүл мэндийн үнэлгээний институтын хамгийн сүүлийн дүн мэдээгээр Монгол Улс насаар стандартчилсан 100 мянган хүн амд ногдох тамхины шалтгаант нас баралтаар дэлхийд есдүгээр байранд орж байна

Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн (НЭМҮТ) 2013 онд хийсэн судалгаагаар Монгол Улсын 15 - 64 насны эрэгтэйчүүдийн дунд тамхины хэрэглээ 49.1% байсан бол эмэгтэйчүүдийн дунд 5.3% буюу нийт 560 гаруй мянган хүн тамхи татаж байна.

Дэлхий дахины залуучуудын тамхины хэрэглээний тандалтын тогтолцооны судалгааны 2016 оны үр дүнгээр Монгол Улсын 13 - 15 насны залуучуудын дундаж тамхи таталтын тархалт 14.3% байна. Энэ үзүүлэлт эрэгтэй сурагчдын хувьд 20.3%, эмэгтэй сурагчдын хувьд 8.3% байв. Тамхи татдаг 10 сурагч тутмын 8 нь буюу 78.9% нь сүүлийн 12 сарын хугацаанд тамхинаас гарахыг оролдож байгаа гэсэн нь тэдэнд ямар нэгэн туслалцаа дэмжлэг үзүүлэх, тамхи татахгүй байх орчин бүрдүүлэх зайлшгүй шаардлагатай болох нь харагдаж байна.

НЭМҮТ-өөс хийсэн ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын эрүүл мэндийн зан үйлийн судалгаагаар сурагчдын 22% нь тамхи татаж үзсэн, 61.4% нь 14 наснаас өмнө сонирхож татсан, 10 орчим хувь нь сүүлийн нэг сард нэг болон түүнээс дээш өдөр тамхи татсан үр дүн гарчээ. Түүнчлэн нийт сурагчдын 44.6% нь дам тамхидалтанд байнга өртдөг буюу эцэг, эх, асран хамгаалагч нь тамхи татдаг байна.

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын Тамхины хяналтын суурь конвенцийн 3 дугаар хэсгийн 6 дугаар зүйлд тамхины татварыг нэмэгдүүлэх нь тамхины хэрэглээг дорвитой бууруулах хамгийн сайн хөшүүрэг болохыг дурдсан байдаг. Тамхины үнийн өсөлт нь тамхичдын тоог цөөрүүлдэг бөгөөд тамхиа үргэлжлүүлэн татсан ч өдөртөө арай цөөн тамхи хэрэглэхэд хүргэдэг.

Тамхины хэрэглээг дорвитой бууруулж чадсан улс орнуудад тамхинд ногдох татварын хэмжээ нь жижиглэн худалдааны үнийн 60% болон түүнээс дээш байна. Тамхины жижиглэн худалдааны үнэ 10%-иар өсөхөд өндөр орлоготой орнуудад хэрэглээ 4%-иар, бага, дунд орлоготой орнуудад 8%-иар буурдаг гэсэн тооцоо бий. Тамхины хэрэглээний тархалт нь хүн амын орлого, нас болон хүн ам зүйн бусад хүчин зүйлээс шалтгаалдаг ба зарим насны бүлэгт хэрэглээ 50 хүртэл хувиар буурдаг. Тамхины өндөр татвар нь ялангуяа өсвөр насныхан тамхи хэрэглэхээс урьдчилан сэргийлэх, хэрэглээг багасгахад маш өндөр үр дүнтэй байдаг. Үнэ өсөхөд залуу хүмүүс бусдыг бодвол хоёроос гурав дахин илүүтэй тамхинаас гарч, эсвэл тамхи бага татдаг байна.

Иймд Монгол Улсын хувьд тамхины онцгой албан татварыг үе шаттайгаар нэмэгдүүлэх бодлогыг авч хэрэгжүүлж ирсэн. Тухайлбал, Монгол Улсын Их Хурлаас 2017 оны 4 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар 2018-аас 2020 он хүртэлх тамхины онцгой албан татварыг үе шаттайгаар нэмэгдүүлэхээр заасан. Харин 2021 оноос цаашид хэрхэн татварыг нэмэгдүүлэх талаарх бодлого одоогоор тодорхойгүй байна. Тийм учраас хуулийн хүрээнд тамхины онцгой албан татварын ямар тодорхой түвшинд нэмэгдүүлэх талаар шийдвэр гаргах хэрэгцээ шаардлага тулгарсан байна.

Олон улсын тэргүүлэгч тамхи үйлдвэрлэгчээс бүтээгдэхүүн хөгжүүлэлтээ улам бүр нэмэгдүүлж халаах болон ууршуулах технологи бүхий электрон төхөөрөмжийн тусламжтайгаар хэрэглэгддэг тамхи, никотин агуулсан шингэн тамхи үйлдвэрлэх болсон.

Дэлхийн томоохон тамхи үйлдвэрлэгч Флипп Моррис Интернэйшнл компанийн судалгаагаар тухайн компанийн 12,7 сая утаат тамхины хэрэглэгч энэ бүтээгдэхүүнийг хэрэглэх болжээ. Монгол Улсын хувьд тамхи худалдаалж байгаа цэгүүдэд хийсэн судалгаагаар сар бүр халаах технологид суурилсан 250,000 хайрцаг тамхи, никотин, эсхүл никотины давс агуулсан шингэн уусмалтай бөгөөд түүнийг нь ууршуулах замаар хүний биед никотин дамжуулах хэрэгсэл сард 40,000 ширхэгийг онцгой албан татваргүйгээр импортлон худалдаалж байна.

Дээрх төрлийн бүтээгдэхүүний хэрэглээ нэгэнт бий болсон тул халаах болон ууршуулах технологи бүхий электрон төхөөрөмжийн тусламжтайгаар хэрэглэгддэг тамхи, никотин агуулсан шингэн тамхины импорт, үйлдвэрлэлийг хуулийн зохицуулалт, стандарттай болгож, онцгой албан татвар ногдуулах шаардлагатай байна.

Дээр дурдсан хууль зүйн үндэслэл болон практик шаардлага, түүнчлэн Хууль тогтоомжийн тухай хуулийн 13 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан "Хууль тогтоомжийн хэрэгцээ шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал"-ын дагуу хийсэн Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хэрэгцээ шаардлагыг урьдчилан тандан судалсан үнэлгээний тайланд үндэслэн Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулна.

Хоёр. Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төслийн зорилго нь тамхины татварыг үе шаттайгаар нэмэгдүүлэх замаар тамхины хэрэглээг бууруулах, түүнчлэн халаах болон ууршуулах технологи бүхий электрон төхөөрөмжийн тусламжтайгаар хэрэглэгддэг тамхи, никотин агуулсан шингэн тамхины импорт, худалдааг хуулийн зохицуулалт, стандарттай болгож, тэдгээрт онцгой албан татвар ногдуулах зэргээр татварын бааз суурийг өргөтгөхөд оршино.

Хуулийн төсөл нь 5 зүйлтэй байхаар боловсруулагдах бөгөөд төсөлд халаадаг болон электрон тамхинд онцгой албан татвар ногдуулах биет нэгжийг тодорхойлж, янжуур болон түүнтэй адилтгах бусад тамхинд ногдуулах онцгой албан татварын хэмжээг 2021-2024 онд 4600-5860 төгрөг, дүнсэн тамхи болон түүнтэй адилтгах задгай тамхинд ногдуулах онцгой албан татварын хэмжээг 2021-2024 онд 3400-4210 төгрөг болгон тус тус үе шаттайгаар нэмэгдүүлэх, халаадаг тамхинд 3180 төгрөгийн, электрон тамхинд 1000 төгрөгийн онцгой албан татвар ногдуулах зэрэг нэмэлт, өөрчлөлтийг тусгана.

Гурав. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар

Монгол Улсын нэгдэн орсон Тамхины хяналтын суурь конвенцид заасан тамхины татварыг нэмэгдүүлэх замаар тамхины хэрэглээг бууруулах суурь зарчмыг хэрэгжүүлэх явцад энэ төрлийн үйлдвэрлэл, худалдаа, импортын үйл ажиллагаа эрхэлдэг иргэн, аж ахуйн нэгжид эдийн засгийн дарамт багатайгаар шийдвэрлэх эрх зүйн орчин бүрдэнэ.

Тодорхой хэмжээнд хэрэглээ бий болсон боловч онцгой албан татвар ногдуулах барааанд хамаарахгүй байгаа халаах болон ууршуулах технологи бүхий электрон төхөөрөмжийн тусламжтайгаар хэрэглэгддэг тамхи, никотин агуулсан шингэн тамхины импорт, үйлдвэрлэлийг хуулийн зохицуулалт, стандарттай болгоно.

Хуулийн төсөл батлагдсанаар онцгой албан татвар ногдуулах бараа бүтээгдэхүүний тоо хэмжээ нэмэгдэж, улсын төсвийн орлого нэмэгдэх, нэмэгдсэн орлогоос хүн амыг халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэхэд чухал ач холбогдол бүхий нийтийн биеийн тамир, идэвхтэй хөдөлгөөнөөр хичээллэх орчин нөхцөлийг бүрдүүлэх боломжтой болно.

Дөрөв. Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаар

Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хуульд нийцүүлэн, Монгол Улсын олон улсын гэрээ, конвенц, бусад хууль тогтоомжтой уялдуулан боловсруулах бөгөөд төсөлтэй холбогдуулан Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл, "Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ батлах тухай" тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл боловсруулна.

---oOo---

ТАНИЛЦУУЛГА

"Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" хуулийн төслийн талаар

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолоор батлагдсан "Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл"-ийн 136-д зарим шинэ төрлийн тамхи, тамхин бүтээгдэхүүний хэрэглээг зохицуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх чиглэлээр Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулахаар тусгагдсан.

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 289 дүгээр тогтоолоор батлагдсан "Халдварт бус өвчинтэй тэмцэх үндэсний хөтөлбөр"-т заасан Хүн амын эрүүл аж төрөх мэдлэг, хандлагыг сайжруулах, байгууллага, аж ахуйн нэгжид эрүүл мэндийг дэмжих орчин бүрдүүлэх замаар халдварт бус өвчинд нөлөөлж байгаа анхдагч болон завсрын эрсдэлт хүчин зүйлсийн тархалтыг бууруулах зорилт /Зорилт 1/-ын хүрээнд "...тамхи ... зэрэг хүний эрүүл мэндэд эрсдэл учруулдаг хэрэглээг үнэ, татварын бодлогоор дамжуулан бууруулах, ... тамхинд ногдуулах албан татварын хэмжээг жижиглэнгийн үнийн 50 хувьд хүргэх, усан болон электрон тамхины зохицуулалтыг утаат тамхины зохицуулалттай адилтгах асуудлыг холбогдох хууль тогтоомжид тусгах замаар шийдвэрлэх"-ээр заасан байна.

Монгол Улсын хувьд тамхины онцгой албан татварыг үе шаттайгаар нэмэгдүүлэх бодлогыг авч хэрэгжүүлж ирсэн бөгөөд Монгол Улсын Их Хурлаас 2017 оны 4 дүгээр сарын 14-ний өдөр батлагдсан Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар 2018-аас 2020 он хүртэлх тамхины онцгой албан татварыг үе шаттайгаар нэмэгдүүлэхээр заасан. Харин 2021 оноос цаашид хэрхэн татварыг нэмэгдүүлэх талаарх бодлого одоогоор тодорхойгүй. Түүнчлэн, тус хэрэглээ нь нэгэнт бий болсон халаах болон ууршуулах технологи бүхий электрон төхөөрөмжийн тусламжтайгаар хэрэглэгддэг тамхи, никотин агуулсан шингэн тамхины импорт, үйлдвэрлэлийг хуулийн зохицуулалт, стандарттай болгож, онцгой албан татвар ногдуулах шаардлага үүсээд байна.

Иймд тамхины онцгой албан татварыг 2021 оноос эхлэн 2024 он хүртэл үе шаттайгаар нэмэгдүүлэх, халаах болон ууршуулах технологи бүхий электрон төхөөрөмжийн тусламжтайгаар хэрэглэгддэг тамхи, никотин агуулсан шингэн тамхины импорт, үйлдвэрлэлийг хуулийн зохицуулалт, стандарттай болгож, онцгой албан татвар ногдуулахаар хуулийн төсөл боловсруулав.

Хуулийн төсөлд онцгой албан татвар ногдуулах бүтээгдэхүүнд халаадаг болон электрон тамхийг нэмж оруулан, халаадаг тамхинд онцгой албан татвар ногдуулах биет нэгжийг 100 ширхгээр, электрон тамхинд онцгой албан татвар ногдуулах биет нэгжийг 10 миллиграммаар тус тус тогтоож, онцгой албан татварын хэмжээг 3180 болон 1000 төгрөгөөр тогтоосон. Онцгой албан татварыг ийнхүү тогтоосноор халаадаг тамхинаас жилд 1,9 тэрбум, электрон тамхинаас жилд 288 сая төгрөгийн орлого олох боломжтой гэж урьдчилан тооцоод байна.

Мөн янжуур болон түүнтэй адилтгах бусад тамхинд ногдуулах онцгой албан татварын хувь хэмжээг 2021 онд 4600 төгрөгөөр тогтоомж, цаашид 2024 он гэхэд

5860 төгрөг, дүнсэн болон түүнтэй адилтгах задгай тамхинд ногдуулах онцгой албан татварын хувь хэмжээг 2021 онд 3400 төгрөгөөр тогтоож, цаашид 2024 он гэхэд 4210 төгрөг болгон тус тус үе шаттайгаар өсгөн нэмэгдүүлэх зохицуулалтыг тус тус тусгаж, эдгээр нэмэлттэй холбогдуулан Онцгой албан татварын тухай хуулийн хэсэг, заалтуудын уялдаа холбоог хангах өөрчлөлтийг тусгав.

Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуультай холбогдуулан "халаадаг тамхи", "электрон тамхи", "тамхи" гэсэн нэр томьёог шинээр тодорхойлон Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт оруулахаар холбогдох хуулийн төслийг боловсруулав. Уг нэмэлтээр "тамхи" гэсэн нэр томьёонд "утаат тамхи", "халаадаг тамхи", "электрон тамхи" аль аль нь хамаарах бөгөөд энэхүү өөрчлөлтийн үр дүнд халаадаг болон электрон тамхины импорт, үйлдвэрлэл, худалдаа хуулийн зохицуулалт, стандарттай болох юм.

Мөн янжуур үйлдвэрлэх зориулалттай тамхины албан татварын хувь, хэмжээг "5" хувиар тогтоон мөрдүүлж байгаа нь Тамхины хяналтын тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасан тамхи үйлдвэрлэгчид татварын хөнгөлөлт болон бусад давуу тал олгохгүй байх зохицуулалтад нийцэхгүй байгаа тул Монгол Улсын Их Хурлын "Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ батлах тухай" 1999 оны 27 дугаар тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулж, тухайн төрлийн тамхины гаалийн албан татварын хувь хэмжээг 30 хувь болгон өөрчлөхөөр Улсын Их Хурлын тогтоолын төсөл боловсруулаа.

ХУУЛЬ САНААЧЛАГЧ

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар сарын ... -ны өдөр

Улаанбаатар хот

ОНЦГОЙ АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Онцгой албан татварын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт дор дурдсан агуулгатай 6, 7 дахь заалт нэмсүгэй:

6	Халаадаг тамхи	100 ширхэг
7	Электрон тамхи болон электрон тамхи цэнэглэх шингэн	10 миллиграмм

2 дугаар зүйл. Онцгой албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай 6.2 дахь хэсэг нэмсүгэй:

1/6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэг:

"6.2.Энэ хуулийн 4.1.2-т заасан барааны тогтоосон биет нэгжид дараах хэмжээгээр онцгой албан татвар ногдуулна:

Д/д	Онцгой албан татвар ногдуулах барааны нэр, төрөл	Биет нэгж	Ногдуулах онцгой албан татварын хэмжээ /төгрөгөөр/			
			2021	2022	2023	2024
1	Янжуур болон түүнтэй адилтгах бусад тамхи	100 ширхэг	4600	5020	5440	5860
2	Дүнсэн болон түүнтэй адилтгах задгай тамхи	1 килограмм	3400	3670	3940	4210
3	Халаадаг тамхи	100 ширхэг	3180			
4	Электрон тамхи болон электрон тамхи цэнэглэх шингэн	10 миллиграмм	1000			

3 дугаар зүйл. Онцгой албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийн "4.1.1, 4.1.2-т" гэснийг "4.1.1-д" гэж, мөн зүйлийн 6.2, 6.3, 6.4, 6.5 дахь хэсгийн дугаарыг "6.3, 6.4, 6.5, 6.6" гэж, мөн зүйлийн 6.7 дахь хэсгийн "6.2-т" гэснийг "6.3-т" гэж, 8 дугаар зүйлийн 8.9 дэх хэсгийн "6.4, 6.5-д" гэснийг "6.5, 6.6-д" гэж, 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсгийн "6.4, 6.5," гэснийг "6.5, 6.6," гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл.Онцгой албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийн 6, 7 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

5 дугаар зүйл.Энэ хуулийг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар сарын ... -ны өдөр

Улаанбаатар хот

ТАМХИНЫ ХЯНАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Тамхины хяналтын тухай хуулийн 3 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай 3.1.12, 3.1.13, 3.1.14, 3.1.15 дахь заалт нэмсүгэй:

3.1.12."халаадаг тамхи" гэж халах хэрэгсэл ашиглан тамхин бүтээгдэхүүнийг халаах явцад үүсэж буй никотин бүхий амааараа сорж татах зориулалттай үйлдвэрийн аргаар бэлтгэсэн тамхийг;

3.1.13."электрон тамхи" гэж никотин, эсхүл орлуулагч агуулсан шингэн уусмалтай, түүнийг халаах, ууршуулах замаар хүний биед дамжуулах хэрэгсэл(нэг удаагийн болон олон удаагийн хэрэглээний)-ийг;

3.1.14."Электрон тамхи цэнэглэх шингэн" гэж электрон тамхи болон түүнтэй адилтгах бусад тамхинд ашиглах зориулалттай никотин, эсхүл орлуулагч агуулсан шингэн, уусмал(нэг удаагийн савлагаатай, эсхүл дүүргэж, сэлбэж хэрэглэхээр савлагдсан байж болно)-ыг;

3.1.15."тамхи" гэж энэ хуулийн 3.1.2, 3.1.12, 3.1.13-т заасныг."

2 дугаар зүйл. Тамхины хяналтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.7.14.дэх заалтын "дотуур байраас 500" гэснийг хасах.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны ... дугаар сарын ... -ны өдөр

Улаанбаатар хот

"Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ батлах тухай" тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай

Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1."Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ батлах тухай" Монгол Улсын Их Хурлын 1999 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 27 дугаар тогтоолын хавсралтын 24 дүгээр бүлгийн 24.03 зүйлийн үндэсний код 2403.19.20 Янжуур үйлдвэрлэх зориулалттай тамхины албан татварын хувь, хэмжээ "5" гэснийг "30" гэж өөрчилсүгэй.

2.Энэ тогтоолыг Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

ОНЦГОЙ АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН ТАНДСАН ТУХАЙ ТАЙЛАН

Улаанбаатар 2021

ГАРЧИГ

НЭГ. АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН БАЙДАЛ

ХОЁР. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫГ ТОДОРХОЙЛСОН БАЙДАЛ

ГУРАВ. АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУД, ЭЕРЭГ, СӨРӨГ ҮР ДАГАВАРТ ХИЙСЭН ХАРЬЦУУЛАЛТ

ДӨРӨВ.СОНГОСОН ХУВИЛБАРЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДАЛСАН БАЙДАЛ

4.1. Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө
4.2. Эдийн засагт үзүүлэх үр нөлөө
4.3. Нийгэмд үзүүлэх үр нөлөө
4.4. Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө

ТАВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫГ ХАРЬЦУУЛСАН ДҮГНЭЛТ

ЗУРГАА. ОЛОН УЛСЫН БОЛОН БУСАД УЛСЫН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТТАЙ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ

6.1. Казахстан улсын хууль тогтоомж
6.2. Бүгд Найрамдах Солонгос Улсын хууль тогтоомжийн товч тойм
6.3. БНХАУ-ын хууль тогтоомжийн товч тойм
6.4. Энгийн тамхи болон электрон тамхины онцгой албан татварын байдал

ДОЛОО.ЗӨВЛӨМЖ

ОНЦГОЙ АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН ТАНДСАН ТУХАЙ ТАЙЛАН

Энэхүү тайланг Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан **"Хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал"**-ын дагуу хийж гүйцэтгэлээ.

НЭГ. АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН БАЙДАЛ

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын "Тамхины хяналтын суурь конвенци"-д манай улс 2004 онд нэгдэн орсон. Энэ конвенцийн 3 дугаар хэсгийн 6 дугаар зүйлд тамхины татварыг нэмэгдүүлэх нь тамхины хэрэглээг дорвитой бууруулах хамгийн сайн хөшүүрэг болохыг уг конвенцид нэгдсэн улсууд хүлээн зөвшөөрч байгааг дурдсан байдаг.

Манай улсад авч хэрэгжүүлж буй тамхины хяналтын талаарх бодлогын арга хэмжээг олон улсын шилдэг туршлагатай харцуулж авч үзэхэд тамхины хяналтыг сайжруулахад гол нөлөө үзүүлдэг татварын хэмжээ олон улсын зөвлөмжөөс бараг 2 дахин бага байдаг.

Тамхины онцгой албан татвар 2020 онд 100 янжуурт 4'180 төгрөг буюу 1 хайрцаг тамхинд 832 төгрөг (US$0.3) бөгөөд хамгийн их зарагдаж буй тамхины үнэд эзлэх татварын хувь хэмжээ нь 33% байна. Энэ нь 2012 онд ногдуулж байсан татварын хувь хэмжээнээс (хамгийн их зарагдаж буй тамхины үнэд эзлэх татварын хувь 49.36% байсан) даруй 30%-аар буурсан байна. Иймд эхний ээлжинд тамхины татварын хэмжээг 2013 оны хэмжээнд хүргэх цаашлаад үе шаттай дараатай нэмэх шаардлагатай байна.

Иймч учраас Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолоор баталсан "Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл"-ийн 136-д зарим шинэ төрлийн тамхи, тамхин бүтээгдэхүүний хэрэглээг зохицуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх чиглэлээр Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулахаар тусгагдсан.

Мөн Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 289 дүгээр тогтоолоор баталсан "Халдварт бус өвчинтэй тэмцэх үндэсний хөтөлбөр"-т заасан Хүн амын эрүүл аж төрөх мэдлэг, хандлагыг сайжруулах, байгууллага, аж ахуйн нэгжид эрүүл мэндийг дэмжих орчин бүрдүүлэх замаар халдварт бус өвчинд нөлөөлж байгаа анхдагч болон завсрын эрсдэлт хүчин зүйлсийн тархалтыг бууруулах зорилт /Зорилт 1/-ын хүрээнд "...тамхи ... зэрэг хүний эрүүл мэндэд эрсдэл учруулдаг хэрэглээг үнэ, татварын бодлогоор дамжуулан бууруулах, архи, тамхинд ногдуулах албан татварын хэмжээг жижиглэнгийн үнийн 50 хувьд хүргэх, усан болон электрон тамхины зохицуулалтыг утаат тамхины зохицуулалттай адилтгах асуудлыг холбогдох хууль тогтоомжид тусгах замаар шийдвэрлэх"-ээр заасан байна.

Мөн "Тамхи" хэмээх нэгдсэн нэр томъёог Тамхины хяналтын тухай хуулиар тухайлан тодорхойлон тусгасан зүйл байдаггүй.

Тамхины Хяналтын Суурь Конвенцид тодорхойлсноор “тамхи” хэмээх нэр томьёо нь Генус никотиана ургамлын нэг аймагт багтдаг түүхий эд хэлбэрээр тарьж ургуулдаг Никотиана Табакум, Никотиана Рустика зэрэг ургамлын төрлийн Nightshade бүлд хамаарах ургамлын нэр юм.

Монгол Улсын зах зээлд нэвтэрч буй шинэ төрлийн инноваци бүтээгдэхүүнүүд технологийн хувьд шингэн, холимог хэлбэрийн тамхийг боловсруулан гаргаж авсан бүрэлдэхүүн хэсгүүдийг ашиглах нь улам түгээмэл болж байна. Эдгээр бүтээгдэхүүнийг тамхи гэсэн ойлголтод хамааруулж хууль эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, нэгдсэн стандарт, хяналттай болгох зайлшгүй шаардлага байна.

Энэхүү тайлангийн зорилго нь одоогийн хүчин төгөлдөр үйлчилж буй “Онцгой албан татварын тухай хууль”-д нэмэлт, өөрчлөлт оруулах хэрэгцээ, шаардлагыг тандан судлахад оршино. Судалгааг Хууль тогтоомжийн тухай хууль болон тус хуульд заасан аргачлалын дагуу гүйцэтгэв.

Санал болгож буй нэмэлт, өөрчлөлттэй холбоотойгоор бий болох эерэг, сөрөг нөлөөллүүдийг харьцуулан дүгнэсэн. Хүний эрх, нийгэм, эдийн засаг, хүрээлэн буй орчны нөхцөл байдалд үзүүлэх нөлөөллийг судалсан урьдчилсан үнэлгээнд үндэслэсэн үр дүнтэй шийдэл нь “Онцгой албан татварын тухай хууль”-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болно.

Тус хуулийн төсөл батлагдсанаар эрх ашиг нь хөндөгдөх магадлалтай оролцогчид нь:

- Хэрэглэгч;
- Гадаадын тамхи үйлдвэрлэгчид;
- Тамхи импортлогчид;
- Дотоодын тамхи үйлдвэрлэгчид;
- Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага;
- Гаалийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага;
- Татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага.

ХОЁР. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫГ ТОДОРХОЙЛСОН БАЙДАЛ

Тус хуулийн төслийн үндсэн зорилго нь олон улсын гэрээ, конвенцид нийцсэн зохицуулалт бий болгох, тамхи гэсэн ойлголтод хамаардаггүй байсан бүтээгдэхүүнийг тамхины зохицуулалтад хамааруулж, тамхидалттай эдийн засгийн аргаар тэмцэх, төсвийн орлогыг нэмэгдүүлэхэд Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай шинэ хуультай холбогдуулан эрх зүйн актуудын уялдааг бий болгох явдал юм.

Асуудлыг дараах аргачлалуудын дагуу зохицуулах боломжтой гэж үзлээ.

- Шинээр зохицуулалт хийхгүйгээр асуудлыг шийдвэрлэх;
- Хэвлэл мэдээлэл болон бусад арга хэрэгслээр дамжуулан олон нийтийг соён гэгээрүүлэх;

- Зах зээлийн механизмаар дамжуулан төрөөс зохицуулалт хийх;
- Төрийн бус байгууллагаар төрийн тодорхой чиг үүргийг гүйцэтгүүлэх;
- Захиргааны шийдвэр гаргах;
- Хууль тогтоомжийн төсөл боловсруулах.

ГУРАВ. АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУД, ЭЕРЭГ, СӨРӨГ ҮР ДАГАВАРТ ХИЙСЭН ХАРЬЦУУЛАЛТ

Хуулийн төсөл боловсруулах аргачлалын тавдугаарт заасны дагуу асуудлыг зохицуулах хувилбаруудыг тодорхойлсноор хоёрдугаар хэсэгт заасан зорилгодоо хүрч чадах эсэх, дээрх зорилтыг биелүүлсэнээр зардлын хувьд эерэг үр дүн байгаа эсэхийг харгалзан дараах аргуудыг хэрэгжүүлэхэд гаргах зардал, өгөөжийг харьцуулан доорх дүгнэлтийг гаргалаа.

Зохицуулалтын хувилбар		Зорилгод хүрэх байдал	Зардал, үр өгөөжийн харьцаа	Үр дүн
1	Тэг хувилбар (арга хэмжээ авахгүй байх)	Өнөөдрийн тулгамдаж буй асуудлууд хэвээр байсаар байх бөгөөд зорилгод хүрэх боломжгүй байна.	Нэмэлт зардал гарахгүй бөгөөд харин сөрөг үр дагаврууд олноор бий болно.	Сөрөг
2	Хэвлэл мэдээллийн хэрэгслээр зар сурталчилгаа, суртал ухуулга явуулах	Тавьсан зорилгодоо хүрэх боломжгүй байна.	Тодорхой хэмжээний зардал гарах хэдий ч асуудлын гол шалтгааныг шийдвэрлэж чадахгүй.	Сөрөг
3	Зах зээлийн механизм хэрэглэх, төрөөс зохицуулалт хийх	Тавьсан зорилгодоо хүрэх боломжгүй байна.	Тодорхой хэмжээний зардал гарах хэдий ч асуудлын гол шалтгааныг тайлж чадахгүй.	Сөрөг
4	Захиргааны шийдвэр гаргах	Зорилгодоо хүрэх боломжгүй.	Асуудлын гол шалтгааныг арилгахад бүрэн нөлөө үзүүлэхгүй бөгөөд сөрөг нөлөөллийг бүрэн арилгах боломжгүй.	Сөрөг, зорилгодоо хүрэх боломжгүй
5	Төрийн бус байгууллагаар төрийн тодорхой чиг үүргийг гүйцэтгүүлэх	Монгол Улсын Үндсэн хуулиар татварын бодлого, арга хэмжээг зөвхөн УИХ-д хэрэгжүүлэхийг зөвшөөрдөг тул энэ арга нь зорилгодоо	Хэрэгжих боломжгүй.	Сөрөг

		хүрэхэд тохиромжгүй юм.		
6	Хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл боловсруулах	Онцгой албан татварыг нэмэгдүүлснээр төрийн төсвийн орлогыг нэмэгдүүлнэ.	Тодорхой хэмжээний зардал гарах хэдий ч асуудлыг шийдвэрлэх гол арга зам болно.	Эерэг

Зорилгодоо хүрэх боломжит байдал, асуудлын эерэг, сөрөг талуудыг үнэлсэний үр дүнд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулах нь асуудлыг шийдвэрлэх цорын ганц арга зам гэж дүгнэн, цаашдын судалгааг хийлээ.

ДӨРӨВ.СОНГОСОН ХУВИЛБАРЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДАЛСАН БАЙДАЛ

4.1.Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1. Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж буй эсэх	**1.1 Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх**			
	1.1.1. Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх	Тийм	**Үгүй**	Сөрөг нөлөө байхгүй
	1.1.2. Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх	Тийм	**Үгүй**	Сөрөг нөлөө байхгүй
	1.1.3. Энэ нь тодорхой бүлгийн эмзэг байдлыг дээрдүүлэхийн тулд авч буй түр тусгай арга хэмжээ мөн бол олон улсын болон үндэсний хүний эрхийн хэм хэмжээнд нийцэж буй эсэх	**Тийм**	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
	1.2. Оролцоог хангах			
	1.2.1. Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцох боломжийг бүрдүүлсэн эсэх	Тийм	**Үгүй**	Сөрөг нөлөө байхгүй
	1.2.2. Ялангуяа зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж буй, эсхүл хөндөгдөж болзошгүй	Тийм	**Үгүй**	Сөрөг нөлөө байхгүй

	иргэдийг тодорхойлсон эсэх			
	1.3. Хууль дээдлэх зарчим ба сайн засаглал хариуцлага			
	1.3.1. Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх	**Тийм**	Үгүй	
	1.3.2. Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээ, НҮБ-ын хүний эрхийн механизмаас тухайн асуудлаар өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх	**Тийм**	Үгүй	
	1.3.3. Хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх	**Тийм**	Үгүй	
2. Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулсан эсэх	2.1. Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарлах бол энэ нь хууль ёсны зорилгод нийцсэн эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.2. Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
3. Эрх агуулагч	3.1. Зохицуулалтын хувилбарт хамаарах бүлгүүд буюу эрх агуулагчдыг тодорхойлсон эсэх	**Тийм**	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.2. Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлсон эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.3. Зохицуулалтын хувилбар нь энэхүү эмзэг бүлгийн нөхцөл байдлыг харгалзан үзэж, тэдний эмзэг байдлыг дээрдүүлэхэд чиглэсэн эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.4. Эрх агуулагчдын, ялангуяа эмзэг бүлгийн ялгаатай хэрэгцээг тооцсон мэдрэмжтэй зохицуулалтыг тусгах эсэх /хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний цөөнх, хэлний	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

	цөөнх, гагцхүү эдгээрээр хязгаарлахгүй/			
4. Үүрэг хүлээгч	4.1. Үүрэг хүлээгчдийг тодорхойлсон эсэх	**Тийм**	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
5. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд	5.1. Жендэрийн үзэл баримтлалыг тусгасан эсэх	**Тийм**	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.2.Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэх эсэх	**Тийм**	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

4.2. Эдийн засагт үзүүлэх үр нөлөө

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1.Дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвар	1.1 Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх үү?	**Тийм**	Үгүй	-
	1.2 Хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэх эсэх /эдийн засгийн байршил өөрчлөгдөхийг оролцуулан/?	Тийм	**Үгүй**	-
	1.3 Дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг Монголын зах зээлд орж ирэхээс хамгаалахад нөлөөлж чадах уу?	Тийм	**Үгүй**	-
2. Дотоодын зах зээлийн өрсөлдөх чадвар болон тогтвортой байдал	2.1 Хэрэглэгчдийн шийдвэр гаргах боломжийг бууруулах уу?	Тийм	**Үгүй**	-
	2.2 Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөрөгдлийг бий болгох уу?	Тийм	**Үгүй**	-
	2.3 Зах зээлд шинээр орж ирж буй аж ахуйн нэгжүүдийн хувьд бэрхшээл, хүндрэлийг бий болгох уу?	Тийм	**Үгүй**	-
	2.4 Зах зээлд шинээр монополийг бий болгох уу?	Тийм	**Үгүй**	-

3.Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн болон захиргааны зардал	3.1 Зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлснээр аж ахуйн нэгжид шинээр зардал үүсэх эсэх	Тийм	**Үгүй**	-
	3.2 Санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх эсэх	Тийм	**Үгүй**	-
	3.3 Зах зээлээс тодорхой бараа бүтээгдэхүүнийг худалдан авахад хүргэх эсэх	Тийм	**Үгүй**	-
	3.4 Бараа, бүтээгдэхүүний борлуулалтад ямар нэг хязгаарлалт, эсхүл хориг тавих эсэх	Тийм	**Үгүй**	-
	3.5 Аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа зогсооход хүргэх эсэх	Тийм	**Үгүй**	-
4.Мэдээлэх үүргийн улмаас үүсч буй захиргааны зардлын ачаалал	4.1 Хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт зардлуудыг /Жишээ нь, мэдээлэх, тайлан гаргах гэх мэт/ бий болгох эсэх	Тийм	**Үгүй**	-
5.Өмчлөх эрх	5.1 Өмчлөх эрхийг /үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, эдийн бус баялаг зэргийг/ хөндсөн зохицуулалт бий болох эсэх	Тийм	**Үгүй**	-
	5.2 Өмчлөх эрх олж авах, шилжүүлэх болон хэрэгжүүлэхэд хязгаарлалт бий болгох эсэх	Тийм	**Үгүй**	-
	5.3 Оюуны өмчийн /патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх зэрэг/ эрхийг зөрчсөн зохицуулалт бий болгох эсэх	Тийм	**Үгүй**	-
6.Инновацийн судалгаа шинжилгээ	6.1 Судалгаа шинжилгээ, нээлт хийх, шинэ бүтээл гаргах асуудлыг дэмжих эсэх	**Тийм**	Үгүй	-
	6.2 Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүнийг нэвтрүүлэх,	**Тийм**	Үгүй	-

	дэлгэрүүлэхийг илүү хялбар болгох эсэх			
7.Хэрэглэгч ба гэр бүлийн төсөв	7.1 Хэрэглээний үнийн түвшинд нөлөө үзүүлэх эсэх	**Тийм**	Үгүй	-
	7.2 Хэрэглэгчдийн хувьд дотоодын зах зээлийг ашиглах боломж олгох эсэх	Тийм	**Үгүй**	-
	7.3 Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх	**Тийм**	Үгүй	-
	7.4 Хувь хүний/гэр бүлийн санхүүгийн байдалд (шууд, мөн урт хугацааны туршид) нөлөө үзүүлэх эсэх	**Тийм**	Үгүй	-
8.Тодорхой бүс нутаг, салбарууд	8.1 Тодорхой бүс нутгуудад тодорхой нэг чиглэлд, ажлын байрыг шинээр бий болгох эсэх	Тийм	**Үгүй**	-
	8.2 Тодорхой бүс нутгуудад тодорхой чиглэлд, ажлын байрыг багасгах чиглэлээр нөлөө үзүүлэх эсэх	Тийм	**Үгүй**	-
	8.3 Жижиг, дунд үйлдвэрүүд, эсхүл аж ахуйн нэгжийн тодорхой салбаруудад онцгой нөлөө үзүүлэх эсэх	Тийм	**Үгүй**	-
9.Төрийн захиргааны байгууллага	9.1 Улсын төсөвт нөлөө үзүүлэх эсэх	**Тийм**	Үгүй	-
	9.2 Шинээр төрийн байгууллага байгуулах, эсвэл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийгдэх шаардлага тавигдах эсэх	Тийм	**Үгүй**	-
	9.3 Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх	Тийм	**Үгүй**	-
10.Микро эдийн засгийн хүрээнд	10.1 Эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд нөлөө үзүүлэх эсэх	**Тийм**	Үгүй	-
	10.2 Хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулах, зах	**Тийм**	Үгүй	-

	зээлийн тогтвортой хөгжлийг дэмжих эсэх			
	10.3 Инфляци нэмэгдэх эсэх	Тийм	**Үгүй**	-
11.Олон улсын харилцаа	11.1 Монгол Улсын олон улсын гэрээтэй нийцэж байгаа эсэх	**Тийм**	Үгүй	-

4.3. Нийгэмд үзүүлэх үр нөлөө

Үзүүлэх үр нөлөө	**Холбогдох асуултууд**	**Хариулт**		**Тайлбар**
1.Ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл	1.1 Шинээр ажлын байр бий болох эсэх	Тийм	**Үгүй**	-
	1.2 Шууд болон шууд бусаар ажлын байрны цомхотгол бий болгох эсэх	Тийм	**Үгүй**	-
	1.3 Тодорхой ажил мэргэжлийн хүмүүс болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	**Үгүй**	-
	1.4 Тодорхой насны хүмүүсийн ажил эрхлэлтийн байдалд нөлөөлөх эсэх	Тийм	**Үгүй**	-
2.Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх	2.1 Ажлын чанар, стандартад нөлөөлөх эсэх	Тийм	**Үгүй**	-
	2.2 Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд нөлөөлөх эсэх	Тийм	**Үгүй**	-
	2.3 Ажилчдын эрх, үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөх эсэх	Тийм	**Үгүй**	-
	2.4 Шинээр ажлын стандарт гаргаж ирэх эсэх	Тийм	**Үгүй**	-
	2.5 Ажлын байранд технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өөрчлөлтийг бий болгох эсэх	Тийм	**Үгүй**	-

3.Нийгмийн тодорхой бүлгийг хамгаалах асуудал	3.1 Шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэх эсэх	Тийм	**Үгүй**	-
	3.2 Тодорхой бүлэг болон хүмүүст сөрөг нөлөө үзүүлэх эсэх. Тухайлбал, эмзэг бүлэг, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ажилгүйчүүдэд, үндэстний цөөнхөд г.м	Тийм	**Үгүй**	-
	3.3 Гадаадын иргэдэд илэрхий нөлөөлөх эсэх	Тийм	**Үгүй**	-
4.Төрийн удирдлага, сайн засаглал, шүүх эрх мэдэл, хэвлэл мэдээлэл, ёс суртахуун	4.1 Засаглалын харилцаанд оролцогчдод нөлөөлөх эсэх	Тийм	**Үгүй**	-
	4.2 Төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм	**Үгүй**	-
	4.3 Төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлөх эсэх	Тийм	**Үгүй**	-
	4.4 Иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлэх эрхэд нөлөөлөх эсэх	Тийм	**Үгүй**	-
	4.5 Улс төрийн нам, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм	**Үгүй**	-
5.Нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал	5.1 Хувь хүний/нийт хүн амын дундаж наслалт, өвчлөлт, нас баралтын байдалд нөлөөлөх эсэх	Тийм	**Үгүй**	-
	5.2 Зохицуулалтын хувилбарын улмаас үүсэх дуу чимээ, агаар, хөрсний чанарын өөрчлөлт хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	**Үгүй**	-
	5.3 Хүмүүсийн амьдралын хэв маяг /хооллолт, хөдөлгөөн, архи, тамхины хэрэглээ/-т нөлөөлөх эсэх	Тийм	**Үгүй**	-
6.Нийгмийн хамгаалал,	6.1 Нийгмийн үйлчилгээний чанар,	Тийм	**Үгүй**	-

эрүүл мэнд, боловсролын систем	хүртээмжид нөлөөлөх эсэх			
	6.2 Ажилчдын боловсрол, шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх эсэх	Тийм	**Үгүй**	-
	6.3 Иргэдийн боловсрол /төрийн болон хувийн хэвшлийн сургуулиар/ олох, мэргэжил эзэмших, давтан сургалтад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	**Үгүй**	-
	6.4 Нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ авахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	**Үгүй**	-
	6.5 Их, дээд сургуулиудын үйл ажиллагаа, өөрийн удирдлагад нөлөөлөх эсэх	Тийм	**Үгүй**	-
7.Гэмт хэрэг, нийгмийн аюулгүй байдал	7.1 Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөөлөх эсэх	Тийм	**Үгүй**	-
	7.2 Хуулийг албадан хэрэгжүүлэхэд нөлөөлөх эсэх	Тийм	**Үгүй**	-
	7.3 Гэмт хэргийн илрүүлэлтэд нөлөөлөх эсэх	Тийм	**Үгүй**	-
	7.4 Гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрхэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	**Үгүй**	-
8.Соёл	8.1 Соёлын өвийг хамгаалахад нөлөө үзүүлэх эсэх	Тийм	**Үгүй**	-
	8.2 Хэл соёлын ялгаатай байдал бий болгох эсэх, эсхүл уг ялгаатай байдалд нөлөөлөх эсэх	Тийм	**Үгүй**	-
	8.3 Иргэдийн түүх, соёлоо хамгаалах оролцоонд нөлөөлөх эсэх	Тийм	**Үгүй**	-

4.4. Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1. Агаар	1.1 Зохицуулалтын үр дүнд агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	**Үгүй**	-
2.Зам тээвэр, түлш эрчим хүч	2.1 Тээврийн хэрэгслийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх/ бууруулах эсэх	Тийм	**Үгүй**	-
	2.2 Эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх эсэх	Тийм	**Үгүй**	-
	2.3 Эрчим хүчний үйлдвэрлэлд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	**Үгүй**	-
	2.4 Тээврийн хэрэгслийн агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	**Үгүй**	-
3.Ан амьтан, ургамал хамгаалах	3.1 Ан амьтны тоо хэмжээг бууруулах эсэх	Тийм	**Үгүй**	-
	3.2 Ховордсон болон нэн ховор амьтан, ургамалд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	**Үгүй**	-
	3.3 Ан амьтдын нүүдэл, суурьшилд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	**Үгүй**	-
	3.4 Тусгай хамгаалалттай газар нутагт сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	**Үгүй**	-
4.Усны нөөц	4.1 Газрын дээрх ус болон гүний ус, цэвэр усны нөөцөд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	**Үгүй**	-
	4.2 Усны бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	**Үгүй**	-
	4.3 Ундны усны чанарт нөлөөлөх эсэх	Тийм	**Үгүй**	-
5.Хөрсний бохирдол	5.1 Хөрсний бохирдолтод нөлөө үзүүлэх эсэх	Тийм	**Үгүй**	-
	5.2 Хөрсийг эвдлэх, ашиглагдсан талбайн хэмжээг нэмэгдүүлэх эсэх	Тийм	**Үгүй**	-
6.Газрын ашиглалт	6.1 Ашиглагдаагүй байсан газрыг ашиглах эсэх	Тийм	**Үгүй**	-

	6.2 Газрын зохицуулалтыг өөрчлөх эсэх	Тийм	**Үгүй**	-
	6.3 Экологийн зориулалтаар хамгаалагдсан газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Тийм	**Үгүй**	-
7.Нөхөн сэргээгдэх/ нөхөн сэргээгдэхгүй баялаг	7.1 Самар, жимс зэрэг нөхөн сэргээгдэх байгалийн баялгийг түүний нөхөн сэргээлтийн хугацаанаас өмнө ашиглах эсэх	Тийм	**Үгүй**	-
	7.2 Нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгийн ашиглалт нэмэгдэх эсэх	Тийм	**Үгүй**	-

ТАВ.ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫГ ХАРЬЦУУЛСАН ДҮГНЭЛТ

	Арга	Зорилгодоо хүрэх байдал	Зардал, өгөөжийн харьцаа	Үр дүн
1	"Тэг" зохицуулалт Одоогийн хууль тогтоомжийг хэрэглэх	Татварын хувь хэмжээг зөвхөн хуулиар өөрчлөн тогтоох боломжтой тул боломжгүй байна.	Төрийн төсөвт тодорхой дүнгээр нэмэгдэхгүй. Нэмэлт зардал гарахгүй.	Сөрөг
2	Төр, төрийн байгуулагаас зохицуулалт хийх	Өөрчлөлт гарахгүй.	Нэмэлт зардал учрахгүй.	Сөрөг
3	Хэвлэл мэдээллээр дамжуулан олон нийтийг соён гэгээрүүлэх	Өөрчлөлт гарахгүй.	Нэмэлт зардал учрахгүй.	Сөрөг
4	Захиргааны шийдвэр гаргах	Өөрчлөлт гарахгүй.	Өөрчлөгдөхгүй.	Сөрөг
5	Төрийн бус байгууллагаар төрийн тодорхой чиг үүргийг гүйцэтгүүлэх	Өөрчлөлт гарахгүй.	Өөрчлөгдөхгүй.	Сөрөг
6	Шинээр хууль батлах шаардлагагүй	Хүрэх боломжгүй.	Нэмэлт зардал учрахгүй. Асуудлыг	Эерэг

			шийдвэрлэх боломжтой.	

ЗУРГАА.ОЛОН УЛСЫН БОЛОН БУСАД УЛСЫН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТТАЙ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ

Дараах үндэслэлээр БНСУ, ОХУ, БНХАУ, Казахстан, Киргиз Улсын хууль журмыг жишиг болгон сонгосон болно.

6.1.Казахстан улсын хууль тогтоомж

2016 оны нэгдүгээр сарын 1-ээс эхлэн Бүгд Найрамдах Казахстан Улсын "Татвар ба төсөвт төлөх бусад төлбөрийн тухай" хуулийн 1-р зүйл, 279-р зүйлд 2018-2022 онд янжуур тамхинд ногдуулах онцгой албан татварын хувь хэмжээг үе шаттайгаар нэмэгдүүлэх төлөвлөгөөг тусгасан.

Өмнөх Татварын хуулийн никотин агуулсан бүтээгдэхүүнд 2016 оноос хойш дөрвөн жилийн хугацаанд “0” хувийн хөнгөлөлт эдлүүлэхээр тогтоосон байна.

Түүнчлэн Татварын хуулиар цахилгаан тамхинд хэрэглэх зориулалттай халаадаг тамхитай бүтээгдэхүүн, никотин бүхий шингэн гэх бүтээгдэхүүнийг хуульчлан тодорхойлсон байна.

Казахстаны онцгой албан татварын хувь хэмжээ:

№	Онцгой албан татвар ногдуулах бараа	Биет нэгж	2018	2019	2020	2021	2022
1	Шүүлтүүртэй болон шүүлтүүргүй янжуур тамхи	1,000 ширхэг	7,500	8,700	9,900	11,300	12,300
2	Ороомол навчин тамхи (Сигарилло)	1000 ширхэг	6,225	6,225	6,225	6,225	6,225
3	Навчин тамхи (Сигар)	1 ширхэг	750	750	750	750	750
4	Никотин агуулсан эмийн бүтээгдэхүүнээс бусад эцсийн хэрэглэгчдэд зориулан сав, баглаа боодолд савласан дүнсэн, татах, зажлах, үнэрлэх, хуука болон бусад тамхин бүтээгдэхүүн	Кг	7,345	7,345	7,345	7,345	7,345
5	Халаадаг тамхитай бүтээгдэхүүн	кг тамхины хольц	0	0	7,345	7,345	7,345
6	Цахилгаан тамхинд хэрэглэх зориулалттай хайрцаг, усан сан бусад савалгаанд байрлуулсан никотин	мл	0	0	5	5	5

	агуулсан хольцоос бүрдсэн, тамхины агууламжгүй никотин бүхий шингэн хэлбэртэй бүтээгдэхүүний төрөл						

6.2.Бүгд Найрамдах Солонгос Улсын хууль тогтоомжийн товч тойм

БНСУ нь электрон тамхины худалдаад хэд хэдэн төрлийн татвар оногдуулдаг бөгөөд 1 мл никотинд шингэнд 1799 вонын татвар, мөн хаягдалд 24 вонын татварыг тус тус ногдуулдаг байна. Түүнчлэн нэмүү өртгийн татвар 10% байна.

6.3.БНХАУ-ын хууль тогтоомжийн товч тойм

БНХАУ-ын хувьд электрон тамхины худалдах үнэд 13%-ын нэмүү өртгийн татвар ногдуулдаг бөгөөд энэ нь ази тивийн бусад улс оронтой харьцуулахад харьцангуй бага юм.

Түүнчлэн 18-аас доош насны иргэнд электрон тамхи зарах сурталчлахыг хатуу хориглодог ба 2018 онд онлайн худалдааг хаасан байна.

6.4.Энгийн тамхи болон электрон тамхины онцгой албан татварын байдал

	Энгийн тамхи	**Навчин тамхи**	**Ороодог тамхи**	**Электрон тамхи**	% of RSP
	USD /1000 ш	USD /1000 ш	USD /1000 гр	USD /1 мил	
Япон	121.41	121.49	112.32		63.1
Өмнөд Солонгос	125.03	-	88.55	1.60	73.8
ОХУ	50 per mil	50 per mil	39.9	12 rub	57.7
БНХАУ	40%	121.49	112.32		55.7
Казахстан	19.93	-	88.55	1.60	63.1

Хүснэгт нь нэр дурдсан таван улсын хувьд энгийн, ороодог, навчин тамхи болон электрон тамхи тус бүрд хэмжих нэгжээр хэрхэн онцгой албан татвар ногдуулж байгааг харуулна. Сүүлийн мөрд тамхины зарах үнэнд ногдуулж байгаа татварын хэмжээг хувиар харуулав.

ДОЛОО. ЗӨВЛӨМЖ

Энэхүү урьдчилсан тандан судалгаанаас шинээр хуулийн төсөл боловсруулах замаар зорилго бүхий асуудлыг зохицуулах нь зардал, өгөөжийн харьцааны тооцоогоор эерэг үр дүнтэй байхаар харагдаж байна. Тиймээс одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Онцгой албан татварын тухай хуульд холбогдох нэмэлт, өөрчлөлтийг оруулах нь зүйтэй байна.

Олон улсын тэргүүлэгч тамхи үйлдвэрлэгчээс бүтээгдэхүүн хөгжүүлэлтээ улам бүр нэмэгдүүлж халаах болон ууршуулах технологи бүхий электрон төхөөрөмжийн тусламжтайгаар хэрэглэгддэг тамхи, никотин агуулсан шингэн тамхи үйлдвэрлэх болсон.

Дэлхийн томоохон тамхи үйлдвэрлэгч Флипп Моррис Интернэйшнл компаний судалгаагаар тухайн компанийн 12,7 сая утаат тамхины хэрэглэгч энэ бүтээгдэхүүнийг хэрэглэх болжээ. Монгол Улсын хувьд тамхи худалдаалж байгаа цэгүүдэд хийсэн судалгаагаар сар бүр халаах технологид суурилсан 250,000 хайрцаг тамхи, никотин, эсхүл никотины давс агуулсан шингэн уусмалтай бөгөөд түүнийг нь ууршуулах замаар хүний биед никотин дамжуулах хэрэгсэл сард 40,000 ширхэгийг онцгой албан татваргүйгээр импортлон худалдаалж байна.

Дээрх төрлийн бүтээгдэхүүний хэрэглээ нэгэнт бий болсон тул халаах болон ууршуулах технологи бүхий электрон төхөөрөмжийн тусламжтайгаар хэрэглэгддэг тамхи, никотин агуулсан шингэн тамхины импорт, үйлдвэрлэлийг хуулийн зохицуулалт, стандарттай болгож, онцгой албан татвар ногдуулах шаардлагатай байна.

Хэдийгээр Тамхины хяналтын тухай хууль гэсэн нэртэй боловч тухай хуулийн нэр томьёо хэсэгт "Тамхи" гэсэн нэр томьёог хуульчлан тодорхойлж, тамхи гэсэн ойлголтод шинээр халаадаг тамхи, электрон тамхийг хамруулан, хуулийн зохицуулалттай болгох хэрэгцээ нэгэнт бий болжээ.

---oOo---

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

1.Хууль тогтоомжийн тухай хууль;

2.Татварын ерөнхий хууль;

3.Тамхины хяналтын тухай хууль;

4.Онцгой албан татварын тухай хууль;

5.Засгийн газрын 2016 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн "Аргачлал батлах тухай" 59 дүгээр тогтоол;

6.Янжуур болон түүнтэй адилтгах бусад тамхи; дүнсэн болон түүнтэй адилтгах бусад тамхинд ногдуулах онцгой албан татварын хэмжээнд өөрчлөлт оруулах талаар хийсэн судалгаа. УБ.,2020 он.

7. https://mofa.gov.mn/exp/ckfinder/userfiles/files/tusgai2019.pdf

8.2010-2019 онд дотоодод үйлдвэрлэсэн янжуур болон дүнсэн тамхины хэмжээ болон төлсөн онцгой албан татварын дүн/Татварын ерөнхий газраас авсан мэдээ/.

9.2016-2020 онд импортлосон янжуур болон дүнсэн тамхины хэмжээ, түүнд ногдуулсан гааль, НӨАТ, онцгой албан татварын дүн /Татварын ерөнхий газраас авсан мэдээ/.

10.Э-тамхины талаар хийсэн Дэлхийн банкны судалгаа. http://documents1.worldbank.org/curated/en/356561555100066200/pdf/E-Cigarettes-Use-and-Taxation.pdf

11.https://www.who.int/tobacco/surveillance/policy/country_profile/chn.pdf?ua=1

---oOo---

ОНЦГОЙ АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН СУДАЛГААНЫ ТАЙЛАН

2021 он

ГАРЧИГ

УДИРТГАЛ

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

ХОЁР. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ

ГУРАВ. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ НЬ ТООЦОХ ХЭСГЭЭ ТОГТООСОН БАЙДАЛ

3.1."Зорилгод хүрэх байдал" шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ сонгосон байдал

3.2."Практикт хэрэгжих боломж" шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ сонгосон байдал

3.3."Ойлгомжтой байдал" шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ сонгосон байдал

3.4."Харилцан уялдаа" шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ сонгосон байдал

ДӨРӨВ.ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ

4.1."Зорилгод хүрэх байдал" шалгуур үзүүлэлтээр үнэлсэн талаар

4.2."Практикт хэрэгжих боломж" шалгуур үзүүлэлтээр үнэлсэн талаар

4.3."Ойлгомжтой байдал" шалгуур үзүүлэлтээр үнэлсэн талаар

4.4."Харилцан уялдаа" шалгуур үзүүлэлтээр үнэлсэн талаар

ТАВ.ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙДАЛ

5.1.Үнэлэлт, дүгнэлт

5.2.Зөвлөмж

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

УДИРТГАЛ

Хууль тогтоомжийн тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэгт "... хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэр /цаашид "хууль тогтоомж" гэх/-ийг санаачлах, боловсруулах ажиллагааны үндэслэл, чанарыг сайжруулах, түүнд олон нийтийн оролцоог хангах, хууль тогтоомжийн төсөлд тавих шаардлагыг тодорхойлох, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр нөлөөг үнэлэх замаар хууль дээдлэх ёсыг бэхжүүлэх..." гэж заасан.

Хуулийн дээрх зорилтын хүрээнд 2017 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөж эхэлсэн Хууль тогтоомжийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах үүднээс Монгол Улсын Засгийн газрын 2016 оны "Аргачлал батлах тухай" 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал"-ын дагуу Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд холбогдох судалгааг хийсэн болно.

Энэхүү судалгаагаар Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үр нөлөөг үнэлж, уг төслийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах замаар утаат тамхины онцгой албан татварыг үе шаттай нэмэгдүүлэх, халаах болон ууршуулах технологи бүхий электрон төхөөрөмжийн тусламжтайгаар хэрэглэгддэг тамхи, никотин агуулсан шингэн тамхины импорт, үйлдвэрлэлийг хуулийн зохицуулалт, стандарттай болгож, онцгой албан татвар ногдуулахад чиглэсэн хуулийн төсөл боловсруулахад хууль санаачлагчид дэмжлэг үзүүлэх, улмаар хуулийн төслийн чанарыг сайжруулах талаар зөвлөмж өгөхийг зорьсон болно.

--- oOo ---

ОНЦГОЙ АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН СУДАЛГААНЫ ТАЙЛАН

НЭГ.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Энэхүү үнэлгээг Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн зүйл, заалтад Хууль тогтоомжийн тухай хуулийн 17 дугаар зүйлд заасны дагуу дүн шинжилгээ хийх, үр нөлөөг тооцож, давхардал, хийдэл, зөрчлийг илрүүлэн хуулийн зүйл, заалтыг ойлгомжтой, хэрэгжих боломжтой байдлаар боловсруулахад зөвлөмж өгөх, улмаар хуулийн төслийн чанарыг сайжруулах зорилгоор гүйцэтгэв.

Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн /цаашид "хуулийн төсөл" гэх/ үр нөлөөг үнэлэх ажиллагааг Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Хууль тогтоомжийн төслийн үр нөлөө тооцох аргачлал"-д /цаашид "Аргачлал" гэх/ заасны дагуу дараах үе шатаар хийлээ.

1. Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгох;
2. Хуулийн төслөөс үр нөлөө тооцох хэсгээ тогтоох;
3. Шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг үнэлэх;
4. Үр дүнг үнэлж, зөвлөмж өгөх.

ХОЁР.ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН ТАЛААР

Үнэлгээнд хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан аргачлалын 2.9 дэх заалтад заасны дагуу 6 шалгуур үзүүлэлтээс дараах 4 шалгуур үзүүлэлтийг сонголоо. Үүнд:

1. Зорилгод хүрэх байдал;
2. Практикт хэрэгжих боломж;
3. Ойлгомжтой байдал;
4. Харилцан уялдаа зэрэг болно.

Шалгуур үзүүлэлтийг сонгосон байдал:

Зорилгод хүрэх байдал:

Шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зорилго нь үзэл баримтлалд тусгасан хуулийн төслийг боловсруулах болсон үндэслэл, шаардлагад нийцсэн эсэх /бүрэн илэрхийлж чадсан эсэх/, хуулийн төслийн зорилго нь утаат тамхины онцгой албан татварыг үе шаттай нэмэгдүүлэх, халаах болон ууршуулах технологи бүхий электрон төхөөрөмжийн тусламжтайгаар хэрэглэгддэг тамхи, никотин агуулсан шингэн тамхины импорт, үйлдвэрлэлийг хуулийн зохицуулалт, стандарттай болгож, онцгой албан татвар ногдуулахад чиглэгдэж байгааг анхаарч, хуулийн төслийн зохицуулалт

нь хуулийн төслөөр зохицуулахаар тавьсан зорилгод хүрч чадах эсэхийг үнэлэхээр энэ шалгуур үзүүлэлтийг сонгов.

Практикт хэрэгжих боломж:

Шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зохицуулалтыг дагаж мөрдөх буюу хэрэгжүүлэх боломж байгаа эсэхийг, тухайлбал хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээд байгаа эсэх, тэдгээр этгээдэд тухайн хуулийн зохицуулалтыг хэрэгжүүлэх боломжтой эсэхийг шалгахаар энэ шалгуурыг сонгов.

Ойлгомжтой байдал:

Хуулийн төсөл нь түүнийг хэрэглэх, хэрэгжүүлэх этгээдийн хувьд ойлгомжтой, логик дэс дараалалтай томьёологдсон эсэхийг шалгахаар энэ шалгуур үзүүлэлтийг сонгов.

Харилцан уялдаа:

Хуулийн төслийг бүхэлд нь Монгол Улсын Үндсэн хууль болон хүчин төгөлдөр үйлчилж байгаа бусад хууль тогтоомжтой нийцэж байгаа эсэх, төрийн байгууллагын чиг үүрэгтэй давхардсан, зөрчилдсөн эсэхийг шалгахаар энэ шалгуур үзүүлэлтийг сонгов.

Бусад шалгуур үзүүлэлтийн талаар:

Хуулийн төсөлд иргэдийн эрх чөлөөг хязгаарлах, аж ахуйн нэгжүүдэд шинээр үүрэг хүлээлгэсэн, эсхүл тухайн хуулийн төслийг хэрэгжүүлэх байгууллагын үйл ажиллагаанд нийцэхгүй зохицуулалт агуулаагүй тул хүлээн зөвшөөрөгдөх байдал шалгуур үзүүлэлтээр үнэлгээ хийх шаардлагагүй гэж үзсэн болно.

Хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбоотой гарах зардлын тооцоог тусгайлан хийгдэх тул зардал шалгуур үзүүлэлтийг сонгоогүй болно.

ГУРАВ. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ ТОГТООСОН БАЙДАЛ

Энэ хэсэгт уг хуулийн төслөөс үр нөлөөг нь үнэлэх хэсгээ тогтоож, сонгосон шалгуур үзүүлэлтийн хүрээнд холбогдох зүйл, заалтыг сонгон авав. Энэхүү зүйл, заалтыг сонгохдоо хууль зүйн хувьд шууд үр дагавар үүсгэж байгаа голлох ач холбогдол бүхий заалтуудыг сонгож авсан. Өөрөөр хэлбэл, тухайн төслийн үр нөлөөг үнэлэхдээ цаг хугацаа, зардал хэмнэх үүднээс хуулийн төсөлд шинээр нэмж орж буй, голлох ач холбогдол бүхий заалтыг сонгож, тухайн сонгож буй зүйл, заалтын үр нөлөөг судлах болно.

Сонгосон шалгуур үзүүлэлтийн дагуу хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон шалгуур үзүүлэлт тус бүрээр авч үзвэл:

“Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан хуулийн төслийг боловсруулах үндэслэл, шаардлагад хуулийн төслийн зохицуулалт нь нийцэж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийх үүднээс хуулийн төслийн үзэл баримтлалтай танилцаж, хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага, хуулийн төслийн зорилго болон зорилгод хүрэхэд чиглэгдсэн, мөн түүнийг тодорхой илэрхийлж чадахуйц зохицуулалтыг сонгов.

Хуулийн төслийн үзэл баримтлалд:

1.Монгол Улсын хувьд тамхины онцгой албан татварыг үе шаттайгаар нэмэгдүүлэх бодлогыг авч хэрэгжүүлж ирсэн. Тухайлбал, Монгол Улсын Их Хурлаас 2017 оны 4 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар 2018-аас 2020 он хүртэлх тамхины онцгой албан татварыг үе шаттайгаар нэмэгдүүлэхээр заасан. Харин 2021 оноос цаашид хэрхэн татварыг нэмэгдүүлэх талаарх бодлого одоогоор тодорхойгүй байна. Тийм учраас хуулийн хүрээнд тамхины онцгой албан татварыг ямар тодорхой түвшинд нэмэгдүүлэх талаар шийдвэр гаргах хэрэгцээ шаардлага тулгарсан;

2.Олон улсын тэргүүлэгч тамхи үйлдвэрлэгчээс бүтээгдэхүүн хөгжүүлэлтээ улам бүр нэмэгдүүлж халаах болон ууршуулах технологи бүхий электрон төхөөрөмжийн тусламжтайгаар хэрэглэгддэг тамхи, никотин агуулсан шингэн тамхи үйлдвэрлэх болсон. Тухайн төрлийн бүтээгдэхүүний хэрэглээ Монгол Улсад нэгэнт бий болсон тул халаах болон ууршуулах технологи бүхий электрон төхөөрөмжийн тусламжтайгаар хэрэглэгддэг тамхи, никотин агуулсан шингэн тамхины импорт, үйлдвэрлэлийг хуулийн зохицуулалт, стандарттай болгож, онцгой албан татвар ногдуулах шаардлагатай гэсэн 2 практик шаардлагад үндэслэн “Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлд заасан Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 289 дүгээр тогтоолоор баталсан “Халдварт бус өвчинтэй тэмцэх үндэсний хөтөлбөр”-т заасан “...тамхи ... зэрэг хүний эрүүл мэндэд эрсдэл учруулдаг хэрэглээг үнэ, татварын бодлогоор дамжуулан бууруулах, тамхинд ногдуулах албан татварын хэмжээг жижиглэнгийн үнийн 50 хувьд хүргэх, усан болон электрон тамхины зохицуулалтыг утаат тамхины зохицуулалттай адилтгах асуудлыг холбогдох хууль тогтоомжид тусгах замаар шийдвэрлэх”-ээр заасныг тус тус хууль зүйн үндэслэл болгон дурджээ.

Хуулийн төслийн үзэл баримтлалд дурдсан дээрх үндэслэл, шаардлагад дурдсанаар тамхины онцгой албан татварыг үе шаттай нэмэгдүүлэх, халаах болон ууршуулах технологи бүхий электрон төхөөрөмжийн тусламжтайгаар хэрэглэгддэг тамхи, никотин агуулсан шингэн тамхины импорт, үйлдвэрлэлийг хуулийн зохицуулалт, стандарттай болгож, онцгой албан татвар ногдуулахад хуулийн төслийн зорилго чиглэгдэж байна.

Аливаа хуулийн зохицуулалт нь хуулийн төсөл боловсруулах болсон хэрэгцээ, шаардлагад нийцсэн байх ёстой учраас нэн түрүүнд хуулийн төслийн зорилгыг хуулийн төслийн үзэл баримтлалд дурдсан үндэслэл, шаардлага болон зорилготой харьцуулан дараах байдлаар үнэлэх хэсгээ тогтоолоо

Хуулийн төслийн хэрэгцээ, шаардлага /Хуулийн төслийн үзэл баримтлалаас/	Хуулийн төслийн зорилго
Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолоор батлсан "Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл"-ийн 136-д зарим шинэ төрлийн тамхи, тамхин бүтээгдэхүүний хэрэглээг зохицуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх чиглэлээр Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулахаар тусгагдсан. Мөн Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 289 дүгээр тогтоолоор батлсан "Халдварт бус өвчинтэй тэмцэх үндэсний хөтөлбөр"-т заасан Хүн амын эрүүл аж төрөх мэдлэг, хандлагыг сайжруулах, байгууллага, аж ахуйн нэгжид эрүүл мэндийг дэмжих орчин бүрдүүлэх замаар халдварт бус өвчинд нөлөөлж байгаа анхдагч болон завсрын эрсдэлт хүчин зүйлсийн тархалтыг бууруулах зорилт /Зорилт 1/-ын хүрээнд "...тамхи ... зэрэг хүний эрүүл мэндэд эрсдэл учруулдаг хэрэглээг үнэ, татварын бодлогоор дамжуулан бууруулах, архи, тамхинд ногдуулах албан татварын хэмжээг жижиглэнгийн үнийн 50 хувьд хүргэх, усан болон электрон тамхины зохицуулалтыг утаат тамхины зохицуулалттай адилтгах асуудлыг холбогдох хууль тогтоомжид тусгах замаар шийдвэрлэх"-ээр заасан байна. Иймд Монгол Улсын хувьд тамхины онцгой албан татварыг үе шаттайгаар нэмэгдүүлэх бодлогыг авч хэрэгжүүлж ирсэн. Тухайлбал, Монгол Улсын Их Хурлаас 2017 оны 4 дүгээр сарын 14-ний өдөр батлсан Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар 2018-аас 2020 он хүртэлх тамхины онцгой албан татварыг үе шаттайгаар нэмэгдүүлэхээр заасан. Харин 2021 оноос цаашид хэрхэн татварыг	Хуулийн төслийн зорилго нь тамхины татварыг үе шаттайгаар нэмэгдүүлэх замаар тамхины хэрэглээг бууруулах, түүнчлэн халаах болон ууршуулах технологи бүхий электрон төхөөрөмжийн тусламжтайгаар хэрэглэгддэг тамхи, никотин агуулсан шингэн тамхины импорт, худалдааг хуулийн зохицуулалт, стандарттай болгож, тэдгээрт онцгой албан татвар ногдуулах зэргээр татварын бааз суурийг өргөтгөхөд оршино.

нэмэгдүүлэх талаарх бодлого одоогоор тодорхойгүй байна. Тийм учраас хуулийн хүрээнд тамхины онцгой албан татварыг ямар тодорхой түвшинд нэмэгдүүлэх талаар шийдвэр гаргах хэрэгцээ шаардлага тулгарсан байна. Олон улсын тэргүүлэгч тамхи үйлдвэрлэгчээс бүтээгдэхүүн хөгжүүлэлтээ улам бүр нэмэгдүүлж халаах болон ууршуулах технологи бүхий электрон төхөөрөмжийн тусламжтайгаар хэрэглэгддэг тамхи, никотин агуулсан шингэн тамхи үйлдвэрлэх болсон. Дээрх төрлийн бүтээгдэхүүний хэрэглээ нэгэнт бий болсон тул халаах болон ууршуулах технологи бүхий электрон төхөөрөмжийн тусламжтайгаар хэрэглэгддэг тамхи, никотин агуулсан шингэн тамхины импорт, үйлдвэрлэлийг хуулийн зохицуулалт, стандарттай болгож, онцгой албан татвар ногдуулах шаардлагатай байна.	

Түүнчлэн хуулийн төслийн зохицуулалт нь хуулийн төслийн зорилгыг хангахад чиглэсэн эсэхийг үнэлэх үүднээс хуулийн төслийн зорилго, зорилтод хүрэхэд чиглэсэн дараах зохицуулалтын үр нөлөөнд үнэлгээ өгөхөөр сонголоо.

Хүснэгт 1.

№	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг
1	Зорилгод хүрэх байдал	Хуулийн төслийн 1, 2 дугаар зүйл.

"Практикт хэрэгжих боломж" гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн 1, 2, 5 дугаар зүйлийг сонгож авав.

"Ойлгомжтой байдал" гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төсөл нь боловсруулалтын хувьд Хууль тогтоомжийн тухай хуулийн Дөрөвдүгээр бүлэг болон Монгол Улсын Засгийн газрын 2016 оны "Аргачлал батлах тухай" 59 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэх, түүнчлэн хуулийг хэрэглэх, хэрэгжүүлэх этгээдүүд

хуулийг ойлгож хэрэглэх, хэрэгжүүлэх боломжтой байдлаар болвсруулагдсан эсэхийг шалгахын тулд хуулийн төслийг бүхэлд нь сонгож авлаа./Хуулийн төсөл нь 5 зүйлтэй./

"Харилцан уялдаа" гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг аргачлалд тусгасан хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх стандарт асуултуудад хариулах замаар уялдаа холбоог шалгахын тулд хуулийн төслийг бүхэлд нь авч үзэхээр тооцлоо. /Хуулийн төсөл нь 5 зүйлтэй./

ДӨРӨВ.ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ

Өмнөх үе шатанд хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгож, үр нөлөөг үнэлэх хэсгүүдийг тогтоосон. Энэ үе шатанд тэдгээр үзүүлэлтүүдэд тохирох дараах шалгах хэрэгслээр үр нөлөөг үнэлэв. Үүнд:

Хүснэгт 2.

№	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Шалгах хэрэгсэл
1	Зорилгод хүрэх байдал	Хуулийн төслийн 1, 2 дугаар зүйл	Зорилгод дүн шинжилгээ хийх
2	Практикт хэрэгжих боломж	Хуулийн төслийн 1, 2, 5 дугаар зүйл	Холбогдох зохицуулалтын практик нөхцөл байдалд шинжилгээ хийх
3	Ойлгомжтой байдал	Хуулийн төслийн зохицуулалтыг бүхэлд нь	Хууль тогтоомжийн тухай хуулийн 25, 28, 29, 30 дугаар зүйл болон Хууль тогтоогжийн төсөл боловсруулах аргачлал[1]-д заасан шаардлагыг ханасан эсэхийг шалгах
4	Харилцан уялдаа	Хуулийн төслийн зохицуулалтыг бүхэлд нь	Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1, 29.1.5, 29.1.7, 29.1.10-т болон Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг шалгах

4.1."Зорилгод хүрэх байдал" шалгуур үзүүлэлтээр үнэлсэн талаар

Хуулийн төслийн үзэл баримтлалд дурдсан хэрэгцээ, шаардлагыг хуулийн төсөлд томьёолсон зорилго, зорилт болон зохицуулалттай харьцуулан үзлээ.

Хуулийн төслийн үзэл баримтлалд дурдсан хэрэгцээ, шаардлагыг хураангуйлан авч үзвэл Монгол Улсад тамхины онцгой албан татварыг ямар тодорхой түвшинд нэмэгдүүлэх талаар шийдвэр гаргах, халаах болон ууршуулах технологи бүхий электрон төхөөрөмжийн тусламжтайгаар хэрэглэгддэг тамхи, никотин агуулсан шингэн

[1] Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт.

тамхины импорт, үйлдвэрлэлийг хуулийн зохицуулалт, стандарттай болгож, онцгой албан татвар ногдуулахад хуулийн төслийн зорилго оршиж байна.

Иймд хуулийн төслийн зохицуулалт нь хуулийн төслийн зорилгыг хангахад чиглэсэн эсэх, тэдгээр нь зорилгыг хангах боломжтой байдлаар томьёологдсон эсэхийг үнэлэхээр хуулийн төслийн зорилгыг сонгож авсан дараах зохицуулалттай харьцуулан дүн шинжилгээ хийлээ.

Хуулийн төслийн 1, 2 дугаар зүйл

1 дүгээр зүйл.Онцгой албан татварын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт доор дурдсан агуулгатай 6, 7 дахь заалт нэмсүгэй:

6	Халаадаг тамхи	100 ширхэг
7	Электрон тамхи	10 миллиграмм

2 дугаар зүйл.Онцгой албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай 6.2 дах хэсэг нэмсүгэй:

1/6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэг:

"6.2.Энэ хуулийн 4.1.2-т заасан барааны тогтоосон биет нэгжид дараах хэмжээгээр онцгой албан татвар ногдуулна:

Д/д	**Онцгой албан татвар ногдуулах барааны нэр, төрөл**	**Биет нэгж**	**Ногдуулах онцгой албан татварын хэмжээ /төгрөгөөр/**			
			2021	2022	2023	2024
1	Янжуур болон түүнтэй адилтгах бусад тамхи	100 ширхэг	4600	5020	5440	5860
2	Дүнсэн болон түүнтэй адилтгах задгай тамхи	1 килограмм	3400	3670	3940	4210
3	Халаадаг тамхи	100 ширхэг	3180			
4	Электрон тамхи	10 миллиграмм	1000			

Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Онцгой албан татварын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 2, 3 дахь заалтад янжуур болон түүнтэй адилтгах бусад тамхи, дүнсэн болон түүнтэй адилтгах задгай тамхинд онцгой албан татвар ногдуулахдаа баримтлах биет нэгжийг заасан байх бөгөөд түүнд халаадаг тамхи, электрон тамхины талаарх зохицуулалт тусгагдаагүй байх тул хуулийн төслийн 1 дүгээр зүйлд тамхины эдгээр

төрөлд онцгой албан татвар ногдуулах биет нэгжийг тусгах нь зүйтэй байна. Харин одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Онцгой албан татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлээр онцгой албан татвар ногдох бараа, үйл ажиллагааг заасан байх бөгөөд түүнд "бүх төрлийн тамхи" гэж заасан. "Бүх төрлийн тамхи" гэдэгт халаадаг тамхи, электрон тамхи багтах эсэх асуудлыг Тамхины хяналтын тухай хуулиар нарийвчлан тодруулах шаардлагатай байна.

Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Онцгой албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийн 6, 7 дахь заалтад янжуур болон түүнтэй адилтгах бусад тамхи, дүнсэн болон түүнтэй адилтгах задгай тамхинд ногдуулах албан татварын хэмжээг 2018 оноос 2020 он хүртэл өсгөн нэмэгдүүлэхээр заасан байна. Үүнд 2021 оноос эхлэн эдгээр тамхинд ногдуулах онцгой албан татварын хэмжээг 2020 оны байдлаар цаашид мөрдөх эсэх, эсхүл үе шаттайгаар нэмэгдүүлэх асуудал тодорхойгүй байна. Түүнчлэн халаадаг тамхи, электрон тамхинд ногдуулах онцгой албан татварын хэмжээг заагаагүй байна.

Иймд хуулийн төслийн 2 дугаар зүйлд Онцгой албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлд 6.2 дахь хэсэг нэмж, янжуур болон түүнтэй адилтгах бусад тамхи, дүнсэн болон түүнтэй адилтгах задгай тамхинд ногдуулах албан татварын хэмжээг 2021 оноос 2024 он хүртэл үе шаттайгаар өсгөн нэмэгдүүлэхээр тусгасан нь хуулийн төслийг зорилгыг хангаж байна гэж үзэх үндэслэлтэй байна.

Үнэлгээ: Энэ хэсэгт дурдсан хуулийн төслийн заалтууд нь хуулийн төслийн үзэл баримтлалд дурдсан шалтгаан, нөхцөлийг шийдвэрлэх боломжтой буюу тавигдсан зорилгод хүрэх боломжтой гэж үзэж байна. Хуулийн төслийн зорилгод бүрэн дүүрэн хүрэхэд Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж "бүх төрлийн тамхи" гэдэгт халаадаг тамхи, электрон тамхийг оруулах асуудлыг шийдвэрлэх шаардлагатай.

4.2."Практикт хэрэгжих боломж" шалгуур үзүүлэлтээр үнэлсэн талаар

Хуулийн төслийн холбогдох заалтыг хэрэгжүүлэх этгээд байгаа эсэх, төсөлд заасан чиг үүргийг хэрэгжүүлэх боломж байгаа эсэхийг хүснэгт-3-аас үзнэ үү.

Хүснэгт 3

Практикт хэрэгжих боломж	Хуулийн төслийн заалт

1	Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээд байгаа эсэх, тэдгээр этгээдэд тухайн хуулийн зохицуулалтыг хэрэгжүүлэх боломжтой эсэх	Хуулийн төслийн 1, 2 дугаар зүйл: **"1 дүгээр зүйл.**Онцгой албан татварын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт доор дурдсан агуулгатай 6, 7 дахь заалт нэмсүгэй: 6 Халаадаг тамхи 100 ширхэг 7 Электрон тамхи 10 миллиграмм **2 дугаар зүйл.** Онцгой албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 6.2 дах хэсэг нэмсүгэй: **1/6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэг:** "6.2.Энэ хуулийн 4.1.2-т заасан барааны тогтоосон биет нэгжид дараах хэмжээгээр онцгой албан татвар ногдуулна:

Д/д	Онцгой албан татвар ногдуулах барааны нэр, төрөл	Биет нэгж	Ногдуулах онцгой албан татварын хэмжээ /төгрөгөөр/			
			2021	2022	2023	2024
1	Янжуур болон түүнтэй адилтгах бусад тамхи	100 ширхэг	4600	5020	5440	5860
2	Дүнсэн болон түүнтэй адилтгах задгай тамхи	1 килограмм	3400	3670	3940	4210
3	Халаадаг тамхи	100 ширхэг	3180			
4	Электрон тамхи	10 миллиграмм	1000			

Үнэлгээ:
Онцгой албан татварын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт "Энэ хуульд заасан импортын бараг Монгол Улсын хилээр оруулж ирсэн тухай бүрт гаалийн байгууллага

		онцгой албан татвар ногдуулж, татварын орлогыг төрийн сангийн дансанд шилжүүлнэ.", мөн зүйлийн 8.2, 8.3 дахь хэсэгт "Монгол Улсын нутаг дэвсгэрт үйлдвэрлэсэн спиртээс бусад барааND ногдуулах онцгой албан татварыг татвар төлөгч сар бүрийн 25-ны өдрийн дотор урьдчилан улсын төсөвт төлнө.", "Монгол Улсын нутаг дэвсгэрт үйлдвэрлэсэн барааND ногдуулах онцгой албан татварын тухайн сарын тайланг татвар төлөгч дараа сарын 5-ны өдрийн дотор татварын албанд тушаана." гэж тус тус заасан. Иймд Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсанаар түүнийг хэрэгжүүлэх байгууллага өөчлөгдөхгүй, онцгой албан татвар ногдуулах, тайлагнах харилцаа хэвээр үргэлжлэх тул хуулийн зохицуулалтыг хэрэгжүүлэх бүрэн боломжтой байна.
2	Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээд байгаа эсэх, тэдгээр этгээдэд тухайн хуулийн зохицуулалтыг хэрэгжүүлэх боломжтой эсэх	Хуулийн төслийн 5 дугаар зүйлд "Энэ хуулийг 2021 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө." гэж заасан. **Үнэлгээ:** Янжуур болон түүнтэй адилтгах бусад тамхи, дүнсэн болон түүнтэй адилтгах задгай тамхинд ногдуулах албан татварын хэмжээг нэмэгдүүлэх, түүнчлэн халаах болон ууршуулах технологи бүхий электрон төхөөрөмжийн тусламжтайгаар хэрэглэгддэг тамхи, никотин агуулсан шингэн тамхинд шинээр онцгой албан татвар ногдуулахад талаар эрх, ашиг сонирхол нь хөндөгдөж буй этгээдэд мэдэгдэх хангалттай хугацаа тогтоосон, хуулийг хэрэгжүүлэх этгээд тодорхой тул хуулийн зохицуулалтыг хэрэгжүүлэх бүрэн боломжтой байна.

4.3."Ойлгомжтой байдал" шалгуур үзүүлэлтээр үнэлсэн талаар

Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавигдах нийтлэг шаардлагыг хүснэгт 4-өөс үзнэ үү.

Хүснэгт 4

№	Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавигдах нийтлэг шаардлага	Хариулт
1	29.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай уялдсан байх;	Хуулийн төсөл нь бүхэлдээ уг шаардлыг хангасан

2	29.1.2.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан байх;	Хуулийн төсөл нь бүхэлдээ уг шаардлыг хангасан
3	29.1.3.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцааны хүрээнээс хальсан асуудлыг тусгахгүй байх;	Тийм асуудал тусгаагүй байна
4	29.1.4.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд үл хамаарах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу хүчингүй болсонд тооцох тухай заалт тусгахгүй байх;	Хуулийн төсөл нь бүхэлдээ уг шаардлыг хангасан
5	29.1.5.зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх;	Хуулийн уг шаардлыг хангасан
6	29.1.6.хэм хэмжээ тогтоогоогүй, тунхагласан шинжтэй буюу нэг удаа хэрэгжүүлэх заалт тусгахгүй байх;	Хуулийн төсөл нь бүхэлдээ уг шаардлыг хангасан
7	29.1.7.бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг эш татах, энэ тохиолдолд эшлэлийг тодорхой хийж, хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх;	Хуулийн төсөл нь бүхэлдээ уг шаардлыг хангасан
8	29.1.8.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаа, хуулийн үйлчлэх хүрээ, эрх зүйн харилцаанд оролцогч хүн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, зохицуулалтад удирдлага болгох, харгалзан үзэх нөхцөл байдал, нийтийн эрх зүйн этгээдийн чиг үүрэг, эрх хэмжээ, тэдгээрийг биелүүлэх журам;	Хуулийн төсөлд ийм харилцааг тусгаагүй
9	29.1.9.шаардлагатай тохиолдолд эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын төрөл, хэмжээ, хуулийн хүчин төгөлдөр болох хугацаа, хууль буцаан хэрэглэх тухай заалт, хуулийг дагаж мөрдөх журмын зохицуулалт, бусад хуулийн зүйл, заалтыг хүчингүй болсонд тооцох, хасах заалт;	Хариуцлагын арга хэмжээг энэ хуулиар зохицуулахгүй
10	29.1.10.шаардлагатай тохиолдолд бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон хууль хүчингүй болсонд тооцох тухай дагалдах хуулийн төслийг боловсруулсан байх;	Засгийн газрын тусгай сангийн тухай хууль болон Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг төслийг боловсруулсан
11	29.1.11.хуулийн төсөл нь хуулийн зорилго гэсэн зүйлтэй байж болох бөгөөд зорилгод тус хуулиар хангахаар зорьж байгаа иргэний үндсэн эрх, бэхжүүлэх үндсэн зарчим, хүрэх үр дүнг тусгана.	Уг төсөлд тусгах шаардлагагүй бөгөөд энэ заалт байхгүй

Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлд заасан хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавигдах нийтлэг шаардлагыг хүснэгт 5-аас үзнэ үү

Хүснэгт 5

№	Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйл.Хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлага	Хариулт
1	30.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томьёог хэрэглэх;	Уг шаардлыг хангасан
2	30.1.2.нэг нэр томьёогоор өөр өөр ойлголтыг илэрхийлэхгүй байх;	Уг шаардлыг хангасан
3	30.1.3.үг хэллэгийг монгол хэл бичгийн дүрэмд нийцүүлэн хоёрдмол утгагүй товч, тодорхой, ойлгоход хялбараар бичих;	Уг шаардлыг хангасан
4	30.1.4.хүч оруулсан нэр томьёо хэрэглэхгүй байх;	Уг шаардлыг хангасан
5	30.1.5.жинхэнэ нэрийг ганц тоон дээр хэрэглэх.	Уг шаардлыг хангасан

Хуулийн төслийн зүйл, заалт нь хэрэгжүүлэх, хэрэглэх этгээдүүдэд ойлгомжтой байдлаар томьёологдсон эсэхийг хүснэгт 6-аас үзнэ үү.

Хүснэгт 6

Ойлгомжтой байдал		Хуулийн төслийн заалт
1	Хуулийн төслийн зохицуулалт түүнийг хэрэглэх, хэрэгжүүлэх этгээдүүдийн хувьд ойлгомжтой, логик дараалалтайгаар боловсруулагдсан эсэх	**"1 дүгээр зүйл.**Онцгой албан татварын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт дор дурдсан агуулгатай 6, 7 дахь заалт нэмсүгэй: 6 Халаадаг тамхи 100 ширхэг 7 Электрон тамхи 10 миллиграмм **Үнэлгээ:** Дээрх зохицуулалт түүнийг хэрэглэх, хэрэгжүүлэх этгээдүүдийн хувьд ойлгомжтой, логик дараалалтайгаар боловсруулагдсан.
2	Хуулийн төслийн зохицуулалт түүнийг хэрэглэх, хэрэгжүүлэх этгээдүүдийн хувьд ойлгомжтой, логик дараалалтайгаар боловсруулагдсан эсэх	**2 дугаар зүйл.**Онцгой албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай 6.2 дах хэсэг нэмсүгэй: **1/6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэг:** "6.2.Энэ хуулийн 4.1.2-т заасан барааны тогтоосон биет нэгжид дараах хэмжээгээр онцгой албан татвар ногдуулна:

Д/д	Онцгой албан татвар ногдуулах	Биет нэгж	Ногдуулах онцгой албан татварын хэмжээ /төгрөгөөр/			
			2021	2022	2023	2024

<table>
<tr><td></td><td></td><td>
<table>
<tr><td></td><td>барааны нэр, төрөл</td><td></td><td></td><td></td><td></td><td></td></tr>
<tr><td>1</td><td>Янжуур болон түүнтэй адилтгах бусад тамхи</td><td>100 ширхэг</td><td>4600</td><td>5020</td><td>5440</td><td>5860</td></tr>
<tr><td>2</td><td>Дүнсэн болон түүнтэй адилтгах задгай тамхи</td><td>1 килограмм</td><td>3400</td><td>3670</td><td>3940</td><td>4210</td></tr>
<tr><td>3</td><td>Халаадаг тамхи</td><td>100 ширхэг</td><td colspan="4">3180</td></tr>
<tr><td>4</td><td>Электрон тамхи</td><td>10 миллиграмм</td><td colspan="4">1000</td></tr>
</table>
Үнэлгээ:
Дээрх зохицуулалт түүнийг хэрэглэх, хэрэгжүүлэх этгээдүүдийн хувьд ойлгомжтой, логик дараалалтайгаар боловсруулагдсан байна.</td></tr>
<tr><td>3</td><td>Хуулийн төслийн зохицуулалт түүнийг хэрэглэх, хэрэгжүүлэх этгээдүүдийн хувьд ойлгомжтой, логик дараалалтайгаар боловсруулагдсан эсэх</td><td>3 дугаар зүйл.Онцгой албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийн “4.1.1, 4.1.2-т” гэснийг “4.1.1-д” гэж, мөн зүйлийн 6.2, 6.3, 6.4, 6.5 дахь хэсгийн дугаарыг “6.3, 6.4, 6.5, 6.6” гэж, мөн зүйлийн 6.7 дахь хэсгийн “6.2-т” гэснийг “6.3-т” гэж, 8 дугаар зүйлийн 8.9 дэх хэсгийн “6.4, 6.5-д” гэснийг “6.5. 6.6-д” гэж, 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсгийн “6.4, 6.5,” гэснийг “6.5. 6.6,” гэж тус тус өөрчилсүгэй.

Үнэлгээ:
Онцгой албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлд шинээр хэсэг нэмж байгаатай холбогдуулан бусад хэсэг, заалтад өөрчлөлт оруулах тухай заасан нь Онцгой албан татварын тухай хуулийг хэрэглэх, хэрэгжүүлэх этгээдүүдийн хувьд ойлгомжтой, логик дараалалтайгаар боловсруулагдсан байна.</td></tr>
<tr><td>4</td><td>Хуулийн төслийн зохицуулалт түүнийг хэрэглэх, хэрэгжүүлэх этгээдүүдийн хувьд ойлгомжтой, логик дараалалтайгаар</td><td>4 дүгээр зүйл.Онцгой албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийн 6, 7 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

Үнэлгээ:
Онцгой албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлд шинээр хэсэг нэмж байгаатай холбогдуулан энэ хэсгийн холбогдох заалтыг хүчингүй болгохоор заасан нь Онцгой</td></tr>
</table>

	боловсруулагдсан эсэх	албан татварын тухай хуулийг хэрэглэх, хэрэгжүүлэх этгээдүүдийн хувьд ойлгомжтой, логик дараалалтайгаар боловсруулагдсан байна.
5	Хуулийн төслийн зохицуулалт түүнийг хэрэглэх, хэрэгжүүлэх этгээдүүдийн хувьд ойлгомжтой, логик дараалалтайгаар боловсруулагдсан эсэх	**5 дугаар зүйл.**Энэ хуулийг 2021 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө. **Үнэлгээ:** Янжуур болон түүнтэй адилтгах бусад тамхи, дүнсэн болон түүнтэй адилтгах задгай тамхинд ногдуулах албан татварын хэмжээг нэмэгдүүлэх, түүнчлэн халаах болон ууршуулах технологи бүхий электрон төхөөрөмжийн тусламжтайгаар хэрэглэгддэг тамхи, никотин агуулсан шингэн тамхинд шинээр онцгой албан татвар ногдуулахад талаар эрх, ашиг сонирхол нь хөндөгдөж буй этгээдэд мэдэгдэх хангалттай хугацаа тогтоосон тул хуулийг хэрэглэх, хэрэгжүүлэх этгээдүүдийн хувьд ойлгомжтой, логик дараалалтайгаар боловсруулагдсан байна.

4.4.“Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн талаар

“Харилцан уялдаа” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг аргачлалд тусгасан хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх стандарт асуултуудад хариулах замаар уялдаа холбоог шалгахын тулд хуулийн төслийн бүх заалтын хүрээнд үзэхээр тооцлоо. Аргачлалын 4.10-т заасан шаардлага, шалгуурын дагуу үнэлсэнийг хүснэгт 7-оос үзнэ үү.

Хүснэгт 8

№	Асуулт	Хариулт	Дүн шинжилгээ
1	Хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх	Тийм	Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зэрэгцүүлэн боловсруулсан тул хуулийн төсөл бүхэлдээ энэхүү шаардлагыг хангасан байна.
2	Хуулийн төслийн “Хууль тогтоомж” гэсэн хэсэгт заасан хуулиудын нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх	Тийм	Ийм зохицуулалт тусгах шаардлагагүй.
3	Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томьёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томьёотой нийцэж байгаа эсэх	Тийм	Хуулийн төсөл бүхэлдээ энэхүү шаардлагыг хангасан байна.

4	Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх	Тийм	Хуулийн төсөл бүхэлдээ энэхүү шаардлагыг хангасан байна.
5	Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх	Үгүй	Хуулийн төслийн хүрээнд давхардал илрээгүй.
6	Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх	Тийм	Хуулийн төсөл бүхэлдээ энэхүү шаардлагыг хангасан байна.
7	Хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх	Үгүй	Хуулийн төслийн хүрээнд орхигдуулсан зохицуулалт илрээгүй.
8	Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх	Үгүй	Давхардал илрээгүй.
9	Төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжтой эсэх	Үгүй	Татвар тогтоох, ногдуулах, тайлагнах харилцааг зөвхөн хуулиар зохицуулах тул төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор ямар нэгэн чиг үүрэг хэрэгжүүлэх боломжгүй байдаг.
10	Татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх	Тийм	Хууль нь өөрөө онцгой албан татварын хэмжээг тогтоох зорилготой.
12	Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгасан эсэх	Үгүй	Хязгаарласан зохицуулалт илрээгүй.
13	Хуулийн төслийн зүйл, заалт жендерийн эрх тэгш байдлыг хангасан эсэх	-	Хуулийн төсөл жендерийн тэгш байдлыг хөндөөгүй байна.
14	Хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх	Үгүй	Өрсөлдөөнийг хязгаарлахад чиглэсэн зохицуулалт илрээгүй.
15	Хуулийн төсөлд авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх	Үгүй	Хуулийн төслөөс ийм төрлийн заалт илрээгүй болно.
16	Хуулийн төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх.	Үгүй	Хуулийн төсөлд хариуцлагын талаар тусгах шаардлагагүй болно.

Дээрх үнэлгээнээс дүгнэж үзвэл хуулийн төслийн зүйл заалт өөр хоорондоо болон Монгол Улсын Үндсэн хууль, бусад хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжтой давхардал үүсгээгүй байна гэж үзлээ.

ТАВ.ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙДАЛ

Хуулийн төсөл нь дэвшүүлсэн зорилгоо хангасан эсэх, практикт хэрэгжих боломжтой эсэх, бусад хуулиудтай хэрхэн уялдсан, хуулийн төслийн найруулга, хэл зүй ойлгомжтой эсэх гэсэн шалгуур үзүүлэлт тус бүрийн дагуу хийсэн үнэлэлтийг нэгтгэн дараах дүгнэлтийг хийж, зөвлөмж боловсрууллаа.

5.1.ҮНЭЛЭЛТ, ДҮГНЭЛТ

Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн үзэл баримтлал болон хуулийн төсөлтэй танилцаж, үр дагавар үүсгэж байгаа гол ач холбогдолтой гэсэн заалтуудыг сонгох болон бүхэлд нь авч үзэж, аргачлалд заасан үе шат бүрийн дагуу хийгдсэн ажиллагааны хүрээнд энэ дүгнэлтийг гаргаж байна:

1.Зорилгод хүрэх байдал шалгуур үзүүлэлтээр:

Хуулийн төслийн зохицуулалт нь хуулийн төслийг боловсруулах болсон хэрэгцээ, шаардлага, үндэслэлүүдтэй нийцэж байгаа болон үзэл баримтлалаар тодорхойлсон зорилгыг бүрэн илэрхийлж чадсан эсэхэд, мөн хуулийн төслийн зорилгыг уг хуулийн бусад зохицуулалт хангаж, илэрхийлж чадахаар бүрэн, гүйцэд томьёологдсон эсэхэд үнэлгээ хийхэд зорилгодоо хүрэх шалгуур үзүүлэлтэд /Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хамт/ нийцсэн гэж дүгнэж байна.

2.Практикт хэрэгжих боломж шалгуур үзүүлэлтээр:

Хуулийн төслөөс сонгож авсан зохицуулалтын хувьд түүнийг хэрэгжүүлэх этгээд тодорхой, тэдгээр этгээдэд тухайн хуулийн зохицуулалтыг хэрэгжүүлэх боломж байгаа тул практикт хэрэгжих боломж шалгуур үзүүлэлтэд нийцсэн гэж дүгнэж байна.

3.Ойлгомжтой байдал шалгуур үзүүлэлтээр:

Хуулийн төслийг бүхэлд нь авч үзэхэд Хууль тогтоомжийн тухай хуулийн 25, 28, 29, 30 дугаар зүйл, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан гэж үзэж байна.

4.Харилцан уялдаа шалгуур үзүүлэлтээр:

Энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалд заасан асуултад хариулах байдлаар шалгасан. Харилцан уялдаатай бадлыг хангасан байна.

5.2.ЗӨВЛӨМЖ

Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үр нөлөөг тооцох ажиллагааны үр дүнд гарсан дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг хүргүүлж байна:

1.Монгол Улсад тамхины онцгой албан татварыг тодорхой түвшинд нэмэгдүүлэх талаар шийдвэр гаргах, халаах болон ууршуулах технологи бүхий электрон төхөөрөмжийн тусламжтайгаар хэрэглэгддэг тамхи, никотин агуулсан шингэн тамхины импорт, үйлдвэрлэлийг хуулийн зохицуулалт, стандарттай болгож, онцгой албан татвар ногдуулах хуулийн төслийн зорилгыг бүрэн дүүрэн хангахын тулд Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хамтад нь боловсруулсан нь зүйтэй байна.

2.Энэхүү хуулийн төслийн хэрэгцээ шаардлагыг урьдчилан тандан судалсан тайлан, хуулийн төслийн үзэл баримтлал, төсөл, танилцуулга, төслийн үр нөлөөг тооцсон үнэлгээний тайлан, зарлын тооцоо зэрэг холбогдох бүрдлийн хамт уг хуулийн төслөөр эрх, ашиг сонирхол нь хөндөгдөх этгээдээр хэлэлцүүлсний үндсэн дээр өргөн мэдүүлэх нь зүйтэй байна.

---oOo---

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

1.Хууль тогтоомжийн тухай хууль;

2.Татварын ерөнхий хууль;

3.Тамхины хяналтын тухай хууль;

4.Онцгой албан татварын тухай хууль;

5.Засгийн газрын 2016 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн "Аргачлал батлах тухай" 59 дүгээр тогтоол;

6.Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсан үнэлгээний тайлан;

7. Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлал;

8.Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.

9.Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

10.Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.

---oOo---

ОНЦГОЙ АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСӨЛД ХИЙСЭН ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН

Улаанбаатар 2021

ГАРЧИГ

НЭГ.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

ХОЁР.ОНЦГОЙ АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ БАТЛАГДСАНААР ИРГЭНД ҮҮСЭХ ЗАРДАЛ

ГУРАВ.ОНЦГОЙ АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ БАТЛАГДСАНААР ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ҮҮСЭХ ЗАРДЛЫН ТАЛААР

ДӨРӨВ.ОНЦГОЙ АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ БАТЛАГДСАНААР УЛСЫН ТӨСӨВТ ҮҮСЭХ ЗАРДЛЫН ТАЛААР

ТАВ.ДҮГНЭЛТ

ОНЦГОЙ АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСӨЛД ХИЙСЭН ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН

НЭГ.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Хууль тогтоомжийн тухай хууль[1]-ийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт "Хууль тогтоомжийн төслийг баталснаар тухайн хууль тогтоомжийн үйлчлэх хүрээнд хамрагдах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлын тооцоог тухай бүр гаргаж, зардал, үр өгөөжийн харьцааг энэ хуулийн 12.1.4-т заасан аргачлалын дагуу тодорхойлно." гэж заасны дагуу Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсанаар уг хуулийн үйлчлэх хүрээнд хамаарах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлыг Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан "Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал" /цаашид "аргачлал" гэх/-ын дагуу тооцлоо.

Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсанаар уг хуулийг хэрэгжүүлэх иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад үүсэх зардал, ачааллыг тооцож, үүнийг хялбарчлах, бууруулах талаар санал боловсруулахад энэхүү тайлан чиглэгдсэн болно.

Хуулийн төслөөс иргэн, хуулийн этгээдийн хүлээж буй үүрэг, төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг тодорхойлохдоо уг төсөл нь "нэмэлт, өөрчлөлт хэлбэрээр бичигдэж байгаа буюу уг харилцаа нь нэгэнт өмнө нь хуулиар зохицуулагдсан харилцаа байх тул шинээр буюу өмнө нь гүйцэтгэж байгаагүй үүрэг болон өмнө гүйцэтгэж байсан боловч тухайн үүргийг хуулийн төслөөр өргөжүүлсэн байвал тэр хүрээнд хязгаарлан зардал тээгч этгээдүүдийн зардлыг тооцох болно.

Хуулийн төслөөр зөвхөн шинээр бий болж байгаа үүрэг эсхүл нь өмнө нь хэрэгжүүлж байсан үүргийг өргөжүүлсэн үүргийг тухайн өргөжүүлсэн хэсэгт зардал тооцогдож байгаа тул бодит статистик болон хугацааг шууд ашиглах боломжгүй тохиолдолд аргачлалын 2.5.2-т "тохиолдлын тоо нь тухайн үүргийг хэдэн хуулийн этгээдэд хүлээлгэж байгааг илэрхийлнэ. Ингэхдээ статистикийн тоо мэдээг ашиглах бөгөөд энэ талаар статистик тоо байхгүй бол баримжаалж тооцно" гэснийг баримтлан статистик тоо байхгүй тохиолдлыг баримжаалан тогтоосон болно.

Тодруулбал, тус аргачлалд зааснаар хуулийн этгээдийн зардлыг тооцохдоо хууль тогтоомжоор төрийн байгууллагаас бусад аж ахуйн нэгж, байгууллагад хүлээлгэж байгаа үүргийг хэрэгжүүлэхэд зарцуулах мөнгөн зардлыг, иргэнд үүсэх зардлыг тооцохдоо хууль тогтоомжоор иргэнд хүлээлгэж байгаа үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан зарцуулах цаг хугацааг тус тус оруулан тооцохоор заасан билээ.

Энэхүү хуулийн төсөл нь тамхины онцгой албан татварыг үе шаттай нэмэгдүүлэх, халаах болон ууршуулах технологи бүхий электрон төхөөрөмжийн тусламжтайгаар хэрэглэгддэг тамхи, никотин агуулсан шингэн тамхины импорт,

[1] "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2015 оны 7 дугаар сарын 03-ны өдрийн 25 дугаарт нийтлэгдсэн.

үйлдвэрлэлийг хуулийн зохицуулалт, стандарттай болгож, онцгой албан татвар ногдуулах өөрчлөлтүүдийг багтаасан тул төр, хуулийн этгээд болон иргэнтэй холбоотой зохицуулалт нэмэгдсэн байна.

Иймд тус аргачлалд заасан журмыг үндэслэн зардлыг төрийн байгууллагын зардал, хуулийн этгээдийн зардал, иргэнд үүсэх зардал гэсэн гурван төрлөөр тооцож гаргалаа.

Мөн тус хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг тооцоход дор дурдсан нийтлэг зарчмыг баримтлан ажилласан болно. Үүнд:

- Хуулийн этгээд, иргэн, төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг нэг бүрийг оновчтой тодорхойлох;
- Үүрэг гүйцэтгэхэд зарцуулах хугацааг тогтооход бодитой хандах;
- Бодит тоо баримт, мэдээлэлд тулгуурлах;
- Аргачлалд заасан тооцоо хийх үе шатыг баримтлах.

ХОЁР.ОНЦГОЙ АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ БАТЛАГДСАНААР ИРГЭНД ҮҮСЭХ ЗАРДАЛ

Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсанаар иргэнд үүсэх зардлыг тооцоолохдоо дараахь үе шатыг баримтална. Үүнд:

1. Иргэний гүйцэтгэх үүргийг тогтоох;
2. Цаг хугацаа болон гарч болох зардлыг тооцох;
3. Тоон үзүүлэлтийг тооцох;
4. Нийт дүнг тооцож гаргах;
5. Хялбарчлах боломжийг шалгах.

Нэгдүгээр үе шатны хүрээнд: Энэ хэсэгт Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг нэг бүрчлэн судалж хуулийн төслөөр иргэнд тодорхой үүрэг гүйцэтгэхийг даалгасан эсэхийг тогтоож, гарах зардлыг тооцно.

Хуулийн төслөөр утаат тамхины онцгой албан татварыг үе шаттайгаар нэмэгдүүлэх, халаах болон ууршуулах технологи бүхий электрон төхөөрөмжийн тусламжтайгаар хэрэглэгддэг тамхи, никотин агуулсан шингэн тамхинд онцгой албан татвар ногдуулахаар заасан нь иргэдэд зардал үүсгэх зохицуулалт болсон гэж үзлээ. Үүнд:

Хүснэгт 1.

<table>
<tr><th>Иргэдэд хамааралтай зохицуулалт</th><th>Иргэнд үүрэг үүсгэсэн эсэх</th></tr>
<tr><td>
2 дугаар зүйл.Онцгой албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 6.2 дах хэсэг нэмсүгэй:

1/6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэг:

“6.2.Энэ хуулийн 4.1.2-т заасан барааны тогтоосон биет нэгжид дараах хэмжээгээр онцгой албан татвар ногдуулна:
<table>
<tr><th rowspan="2">Д/д</th><th rowspan="2">Онцгой албан татвар ногдуулах барааны нэр, төрөл</th><th rowspan="2">Биет нэгж</th><th colspan="4">Ногдуулах онцгой албан татварын хэмжээ /төгрөгөөр/</th></tr>
<tr><th>2021</th><th>2022</th><th>2023</th><th>2024</th></tr>
<tr><td>1</td><td>Янжуур болон түүнтэй адилтгах бусад тамхи</td><td>100 ширхэг</td><td>4600</td><td>5020</td><td>5440</td><td>5860</td></tr>
</table>
</td><td>Энэ нь иргэдэд шууд үүрэг хүлээлгэсэн зохицуулалт биш боловч тамхинд ногдуулах онцгой албан татварыг нэмэгдүүлснээр иргэнээс шууд гарах зардлыг нэмэгдүүлэх үр дагавар үүсгэхээр байна.</td></tr>
</table>

2	Дүнсэн болон түүнтэй адилтгах задгай тамхи	1 килограмм	3400	3670	3940	4210	
3	Халаадаг тамхи	100 ширхэг	3180				
4	Электрон тамхи	10 миллиграмм	1000				

Дээрх хуулийн зохицуулалтуудаас харахад янжуур болон түүнтэй адилтгах бусад тамхи, дүнсэн болон түүнтэй адилтгах задгай тамхинд ногдуулах албан татварыг нэмэгдүүлэх, түүнчлэн халаадаг болон электрон тамхинд онцгой албан татвар шинээр ногдуулахаар заасан нь иргэнд шууд зардал бий болгох шинжтэй тул үүнтэй холбоотойгоор эдгээр төрлийн тамхийг худалдан авахад иргэнд нэмэлтээр гарах шууд зардлыг тооцлоо.

Хоёрдугаар үе шатны хүрээнд: Тамхи худалдан авахтай холбоотой зардлыг өмнөх цаг хугацааны өгөгдөл болон тамхины худалдааны үнэ нэмэгдэх төсөөллийг үндэслэн тооцлоо.

Онцгой албан татварын тухай хуулийн дагуу энэ онд янжуур тамхи болон түүнтэй адилтгах бусад тамхины 100 ширхэг тутамд 4180 төгрөг буюу 1 хайрцаг янжуур тамхинд 836 төгрөг, 1кг дүнсэн тамхи болон түүнтэй адилтгах задгай тамхинд 3130 төгрөгийн татвар оногдуулахаар заасан байна. Энэхүү татварын хэмжээ нь одоогийн тамхины үнийн (1 хайрцаг янжуур тамхины дундаж үнэ 3180 төгрөг) 26.2%-ийг эзэлж байна.

Тамхины онцгой албан татварын хэмжээг эхний ээлжид алгууараар буюу 1 ширхэг янжуур тамхинд жил бүр 4.2 төгрөгийн татвар, 1 кг дүнсэн тамхинд 270 төгрөг нэмэхээр тооцоолбол 2024 он гэхэд тамхины онцгой албан татварын хэмжээ худалдаалагдаж буй эцсийн үнийн 36.8% хүрэхээр байна.

Хүснэгт 2.

Он	2020 (өмнөх оны байдлаар)	2021	2022	2023	2024
100 ширхэг янжуур (5 хайрцаг) болон түүнтэй адилтгах тамхи					
Онцгой албан татвар (төг)	4,180	4600	5020	5440	5860
Онцгой албан татварын худалдааны үнэд эзлэх хувь (%)	26.2%	28.9%	31.6%	34.2%	36.8%
1кг дүнсэн тамхи болон түүнтэй адилтгах тамхи					
Онцгой албан татвар (төг)	3130	3400	3670	3940	4210
Онцгой албан татварын худалдааны үнэд эзлэх хувь (%)	28%	30.4%	32.8%	35.2%	37.6%

Гуравдугаар үе шатны хүрээнд: Тоон үзүүлэлтийг тооцох үе шатанд тухайн үүргийг гүйцэтгэхэд иргэн хэдэн удаа хэрэгжүүлэхийг тооцох шаардлагатай боловч энэ тохиолдолд иргэний тамхины хэрэглээг авч үзэх шаардлагатай тул "2006 онд нэг иргэнд жилд дунджаар 505 ширхэг янжуурын хэрэглээ оногдож байсан бол энэ тоо 2019 онд 1487 ширхэг болж сүүлийн 10 гаруй жилд 2.9 дахин өссөн"[2] гэсэн судалгааны мэдээллийг ашиглаж тооцооллыг гүйцэтгэв.

Дөрөвдүгээр үе шатны хүрээнд: Зардлыг тооцохдоо янжуур тамхины 1 ширхэгийн үнийг өнөөдрийн байдлаар 159 төгрөг (1 хайрцаг янжуур тамхины дундаж үнэ 3180 төгрөг) байхаар, цаашид жил тутам 4.2 төгрөгөөр өсөн нэмэгдэх байдлаар баримжаалан тооцоход:

Хүснэгт 3.

Иргэн	ОН				
	2020	**2021**	**2022**	**2023**	**2024**
Гарах зардал/төгрөгөөр/	236,433	242,678	248,924	255,169	261,414
Зөрүү		**6,245.4**	**12,491**	**18,736**	**24,982**

Дээрх тооцооллоос харахад дунджаар янжуур тамхи хэрэглэгч иргэний зардал жил тутамд **6245** төгрөгөөр нэмэгдэж бөгөөд 2020 онтой харьцуулахад 2024 он гэхэд жилд нийт **24,982** төгрөгийн нэмэлт зардал гарахаар байна.

Монгол Улсын хувьд тамхи худалдаалж байгаа цэгүүдэд хийсэн судалгаагаар сар бүр халаах технологид суурилсан 250,000 хайрцаг тамхи, никотин, эсхүл никотины давс агуулсан шингэн уусмалтай бөгөөд түүнийг нь ууршуулах замаар хүний биед никотин дамжуулах хэрэгсэл сард 40,000 ширхэгийг онцгой албан татваргүйгээр импортлон худалдаалж байгаа[3] дүн мэдээ бий боловч тухайн барааны зах зээлийн үнэлгээг нарийвчлан гаргах боломжгүй байна.

Харин хуулийн төсөлд тусгагдсанаар халаадаг тахины 100 ширхэг тутамд 3180 төгрөг ногдуулахаар тооцвол 1 хайрцаг энэ төрлийн тамхины үнэ 636 төгрөгөөр нэмэгдэж, хэрэглэгч иргэнээс гарах зардал мөн хэмжээгээр нэмэгдэх бол электрон тамхины хувьд нэгжид ногдуулах онцгой албан татварын хэмжээ буюу 1000 төгрөгөөр иргэний зардал нэмэгдэнэ.

Тавдугаар үе шатны хүрээнд: Тамхины онцгой албан татварыг төрийн бодлого, шийдвэрийн хүрээнд нэмэгдүүлэхээр хуулийн төсөлд тусгасан тул хэрэглэгч иргэн өөрөө худалдан авах тамхины хэмжээг бууруулах, эсхүл тамхинаас гарахаас өөрөөр хялбарчлах боломжгүй байна.

---

[2] Янжуур болон түүнтэй адилтгах бусад тамхи; дүнсэн болон түүнтэй адилтгах бусад тамхинд ногдуулах онцгой албан татварын хэмжээнд өөрчлөлт оруулах талаар хийсэн судалгаа. УБ.,2020 он.

[3] Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлал.

ГУРАВ.ОНЦГОЙ АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ БАТЛАГДСАНААР ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ҮҮСЭХ ЗАРДЛЫН ТАЛААР

Энэ хэсэгт Онцгой албан татварын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсанаар хуулийн этгээд тамхины импорт, үйлдвэрлэл, худалдаа эрхлэх явцад захиргааны байгууллагатай харилцах явцад тодорхой төрлийн үүрэг гүйцэтгэхийг хуулийн этгээдэд даалгасан буюу шаардсан бол үүний дагуу хуулийн этгээдэд үүсэх зардлыг мөнгөн дүнгээр тооцоолон гаргах юм.

Ийнхүү үүсэх зардлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын дөрөвдүгээр хавсралтаар баталсан "Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал"-ын 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэгт заасны дагуу дараах үе шаттайгаар тооцоолно. Үүнд:

1.Хуулийн тэгээдийн гүйцэтгэх үүргийг тогтоох;
2.Нэг бүрийн зардлыг тооцох;
3.Тоон үзүүлэлтийг тооцох;
4.Нийт зардлын дүнг тооцож гаргах;
5.Хялбарчлах боломжийг шалгах;
6.Нэмэлт зардлыг тооцох.

Нэгдүгээр үе шатны хүрээнд: Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хүрээнд хуулийн этгээдэд ямар үүргийг шинээр бий болгож байгааг тодорхойлж уг үүргийг гүйцэтгэхэд шаардлагатай баримт бичгийн агуулгыг тодорхойлсоны үндсэн дээр зардлын тооцоог хийх болно.

Хуулийн төслийг судлан үзэхэд хуулийн этгээдэд шууд үүрэг бий болгосон заалт байхгүй байна. Харин хуулийн этгээдэд хамааруулж авч үзэх заалт нь энэ тайлангийн "Хоёр" дахь хэсэгт заасан иргэдэд хамаарал бүхий зохицуулалттай давхцаж байна. Өөрөөр хэлбэл, тамхины онцгой албан татварыг нэмэгдүүлэх, халаадаг болон электрон тамхинд шинээр онцгой албан татвар ногдуулах зохицуулалт нь тамхины импорт, үйлдвэрлэл эрхлэгч хуулийн этгээдүүдэд хамааралтай байна. 2019 оны байдлаар Монгол Улсын хэмжээнд янжуур тамхи импортлох тусгай зөвшөөрөлтэй 10, тамхи үйлдвэрлэх тусгай зөвшөөрөлтэй 2 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулдаг.[4]

Халаадаг болон электрон тамхийг импортлох, үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл авах, татварын тайлан гаргах зэрэг Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орсонтой холбоотой хуулийн этгээдэд үүсэх зардал нь Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 13 дугаар зүйлд заасан татвар ногдох орлогоос хасагдах зардалд хамаарах тул хуулийн этгээдээс нэмэлт зардал гарахгүй.

Мөн тамхины онцгой албан татварын нэмэглийг хулдалдааны үнэд шингээн эцсийн хэрэглэгчид хүргэдэг тул янжуур болон түүнтэй адилтгах бусад тамхи, дүнсэн болон түүнтэй адилтгах задгай тамхинд ногдуулах албан татварыг нэмэгдэл нь хуулийн этгээдэд нэмэлт зардал үүсгэхгүй.

---

[4] https://mofa.gov.mn/exp/ckfinder/userfiles/files/tusgai2019.pdf

Иймд аргачлалд заасны дагуу цаашид зардал үүсгэх эсэхийг тооцоолох шаардлагагүй бөгөөд Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь хуулийн этгээдэд зардал үүсгэхгүй гэж үзлээ.

ДӨРӨВ.ОНЦГОЙ АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ БАТЛАГДСАНААР УЛСЫН ТӨСӨВТ ҮҮСЭХ ЗАРДЛЫН ТАЛААР

Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн дагуу төрийн байгууллага буюу улсын төсөвт үүсэх зардлыг тооцоолохдоо дараах дараалыг баримтлах болно. Үүнд:

1.Төрийн байгууллагын гүйцэтгэх үүргийг тогтоох;
2.Уг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөцийг тодорхойлох;
3.Гарах зардлыг тодрхойлох;
4.Зардлын төрлүүдийг нэгтгэн тооцох;
5.Хувилбарыг нягталж, үр дүнг танилцуулах.

Нэгдүгээр үе шатны хүрээнд: Энэ хэсэгт төслийн зохицуулалтыг уншиж судлах замаар тодорхой үүрэг хүлээж буй байгууллага байгаа эсэхийг тодорхойлж, уг байгууллага нь ямар чиг үүрэг буюу ажил үйлчилгээ шинээр гүйцэтгэх, эсхүл одоо гүйцэтгэж байгаа чиг үүрэг, ажил үйлчилгээ хуулийн төслийн дагуу өргөжиж байгаа эсэхийг хуулийн төслөөс тогтоох юм.

Гүйцэтгэх чиг үүрэг гэдэгт хуулийн төслөөр төрийн холбогдох байгууллагад даалгасан бүртгэл хийх, зөвшөөрөл олгох зэрэг төрийн байгууллагаас үзүүлж буй ажил үйлчилгээг ойлгох юм.

Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг судлан үзэхэд шинээр лийн буюу зардал үүсгэх боломжтой үүргийг шинээр бий болгоогүй байна. Өөрөөр хэлбэл, татвар, гаалийн байгууллага одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа татварын хууль тогтоомж болон Онцгой албан татварын тухай хуульд заасан үндсэн чиг үүргээ үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

Төрийн байгууллагад шинээр үүрэг үүсгээгүй байх тул цаашид зардал үүсгэх эсэхийг тооцоолох шаардлагагүй бөгөөд Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь төрд зардал үүсгэхгүй гэж үзлээ.

Харин татварын бааз суурь нэмэгдэх, янжуур болон дүнсэнд тамхинд ногдуулах онцгой албан татварын хэмжээ нэмэгдэх тул улсын төсөвт нэмэлт орлого орно.

ТАВ.ДҮГНЭЛТ

Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн зардлыг Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан "Хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал"-ыг баримтлан тооцоолов.

Хуулийн төслийн судлан үзэхэд төсөл нь зардал тээгч 3 этгээдээс зөвхөн иргэнд зардал үүсгэх зохицуулалт агуулсан байна. Энэ нь Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн нийгэмд үзүүлэх хэтийн үр нөлөө нь тамхины худалдааны үнийг нэмэгдүүлэх замаар тамхидалтыг бууруулах, шинжлэх ухаан, инновацийн шинэ бүтээгдэхүүн болох халаах болон электрон тамхинд шинээр онцгой албан татвар ногдуулах зохицуулалт агуулсантай холбоотой юм.

Иймээс уг хуулийн төсөл нь улсын төсөвт ачаалал үүсгэхгүй. Улсын төсөвт ачаалал үүсгэхгүй тул зардлыг бууруулах талаар санал гаргаагүй болно.

--- oOo ---

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

1.Хууль тогтоомжийн тухай хууль;

2.Татварын ерөнхий хууль;

3.Тамхины хяналтын тухай хууль;

4.Онцгой албан татварын тухай хууль;

5.Засгийн газрын 2016 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн "Аргачлал батлах тухай" 59 дүгээр тогтоол;

6.Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсан үнэлгээний тайлан;

7.Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлал;

8.Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.

9.Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

10.Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.

11.Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээний тайлан.

12.Янжуур болон түүнтэй адилтгах бусад тамхи; дүнсэн болон түүнтэй адилтгах бусад тамхинд ногдуулах онцгой албан татварын хэмжээнд өөрчлөлт оруулах талаар хийсэн судалгаа. УБ.,2020 он.

13. https://mofa.gov.mn/exp/ckfinder/userfiles/files/tusgai2019.pdf

14.2010-2019 онд дотоодод үйлдвэрлэсэн янжуур болон дүнсэн тамхины хэмжээ болон төлсөн онцгой албан татварын дүн/Татварын ерөнхий газраас авсан мэдээ/.

15.2016-2020 онд импортлосон янжуур болон дүнсэн тамхины хэмжээ, түүнд ногдуулсан гааль, НӨАТ, онцгой албан татварын дүн /Татварын ерөнхий газраас авсан мэдээ/.

---oOo---